



# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.03.18, ДАВАА ~ №049 (1101)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

**Бид мөхөл рүүгээ биш юм бол хаашаа явна гэж...**

Ингэж бичсэнээрээ ирээдүй үеэ басамжилсангүй, басхүү өнгөрсөн үе рүүгээ нулимсангүй. >3

**Танд орхигдсон зүйлс бусдад чухал хэрэглээ болно**

Өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангана. >4

**Улс төр, эдийн засгийн бүлэглэлийн дайн хамгийн том эрсдэл**

ДНБ-ий өсөлтийг эдийн засгийн өсөлт гэж тайлбарлаж болохгүй. >11

**FULL ENGLISH PAGE INSIDE**

ZGM DAILY >7

**ОНЦЛОХ**

- УЛС ТӨР**  
Д.Сумъяабазар “Эрдэнэт”-ийн 49 хувьтай холбоотой асуудлыг шийдэх гарц нь “хэлцэл хийх” гэв. АН-ын залуус ЖДҮХС-гаас мөнгө авсан улстөрчдөд хариуцлага тооцохыг шаардлаа.
- ЭДИЙН ЗАСАГ**  
“Баянгол Зочид буудал” нэгж хувьцаанд 355 төгрөгийн ногдол ашиг хуваарилна. БНХАУ “Бүс ба зам” санаачилгад нэгдэхийг АНУ болон Европын компаниудад уриаллаа.
- НИЙГЭМ**  
УБ-Дарханы чиглэлийн 204.16 км замыг \$83.8 саян хөнгөлөлттэй зээлээр барина. Баасан гарагт нээлтээ хийсэн “Нойрны төв” долоо хоногт гурван хүнд үйлчилнэ.
- ДЭЛХИЙ**  
Хятадын Ардын Чөлөөлөх Армид Google-ийг тус болж байна хэмээн Трамп шүүмжиллээ.

## БИЗНЕС ЭРХЛЭГЧИД МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫГ АВЛИГАД ХАМГИЙН ИХ ИДЭГДСЭН ГЭВ



2018 онд бизнесийн орчинд тулгарсан хамгийн гол бэрхшээлийг “өндөр татвар” гэж энэ салбарынхан мэдэгдлээ. Мөн бизнес эрхлэгчдээс “албан бус татвар” нэхдэг байгууллагын тоонд шүүх, цагдаа, шийдвэр гүйцэтгэх байгууллага орж байгаа нь анхаарал татна. ▶ 5

**НОМИН ХОЛДИНГ**

**НОМИН ХОЛДИНГ ХХК НЬ НЭГДСЭН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ 3 СТАНДАРТЫГ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛСЭНЭЭ ДАХИН БАТАЛГААЖУУЛЛАА**

“Номин Холдинг” ХХК нь 2017 онд олон улсын Нэгдсэн удирдлагын тогтолцооны гурван стандартыг нэгэн зэрэг амжилттай нэвтрүүлсэн анхны компани болсон билээ. Ийнхүү нэвтрүүлсэн стандартыг жил бүр баталгаажуулах шаардлагатай бөгөөд 2019.03.11 өдөр олон улсын аудитын SGS компанийн шилдэг аудиторуд ирж, дээрх стандартуудыг үйл ажиллагаандаа хэрхэн нэвтрүүлж байгааг үнэлгээ өглөө. Аудитын дүгнэлтээр Номин Холдинг ХХК нь өнгөрсөн 1 жилийн хугацаанд дээрх стандартуудыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлж, мөрдөж ажилласан болохыг баталгаажуулсан юм. Бид энэхүү стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлын хүрээнд 2018 онд дараах ажлуудыг зохион байгууллаа.

**ISO14001 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

- Номин Юнайтед, Улсын их дэлгүүр, Номин их дэлгүүр, Улаанбаатар импекс салбаруудад 5000м2 орчим ногоон байгууламжийг шинээр байгууллаа.
- “Полипак”, “Сайн цаас” зэрэг түүхий эд хүлээн авч боловсруулдаг компаниудтай хамтран ажиллаж, 11,000 кг хагдал гялгар уут тушааж байгаль орчныг бохирдолоос хамгаалах үйлсэд хувь нэмрээ орууллаа.
- Оффисын ажлын хэрэгцээндээ цаасны хэрэглээг багасгах зорилгоор байгууллагын дотоод үйл ажиллагаанд өдөр бүр давтагдан хэрэглэгдэх зөвшөөрөл хүсэх, хянах, багтах процессуудыг бүрэн автоматжуулсан ERP систем, цахим гарын үсгийг нэвтрүүлсэнээр цаасны хэрэглээг бодитоор бууруулж чадлаа.

**OHSAS 18001 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

- Эрүүл, аюулгүй ажлын байрыг нэмэгдүүлэх, осол эндэгдлийг бууруулах зорилгын хүрээнд нийт ажлын байрны эрсдэлийг тодорхойлж, тодорхой давтамжтай эрсдэлийн бууралтыг хянах, сайжруулах ажлыг зохион байгуулсанаар нийт бүртгэгдсэн эрсдэлийн 96.1% -ийг бууруулж чадсан байна.
- Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлсэнээр 1294 эрсдэлийг тодорхойлж, бууруулсан нь 60 эмнэлзгийн тусламж, 20 эд хөрөнгийн хохирол, 2 нас баралтаас урьдчилан сэргийлсэн байна.

**ISO 9001 стандартыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд:**

- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа
- Харилцагчийн сэтгэл ханамжийн судалгаа
- Ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг 3 талт хэлбэрээр хийж, сайжруулах арга замуудыг тодорхойлсоноор хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индекс өнгөрсөн оноос 0.27 функтээр нэмэгдсэн байна.

**ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НОМИН ХОЛДИНГ ХХК**

**TDB**  
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 98-Н ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН “МАРШ ТАКТИК - 2019” ТЭМЦЭЭН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ ӨНГӨРЛӨӨ.**

“Монгол цэргийн өдөр”, Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны түүхт 98-н жилийн ойг тохиолдуулан, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, хүүхэд залуучууд, өсвөр үеийнхэнд цэрэг, эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор ХХБанкны Хамгаалалт, аюулгүй байдлын газрын нийт бүрэлдэхүүн 2019 оны 03-р сарын 16-ны өдөр Зэвсэгт хүчний 311-р ангийн хээрийн полигонд “МАРШ ТАКТИК - 2019” тэмцээнийг уламжлал ёсоор тав дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Тус тэмцээн нь ХХБанкны хамгаалалтын нийт бүрэлдэхүүний гар санаа нийлсэн хамтач ажиллагаа, багаар ажиллах чадвар, сахилга дэг журам, тэсвэр хатуужлыг төлөвшүүлж, хамгаалалт аюулгүй байдлын ажлын арга тактик, ур чадвар, тусгай бэлтгэлийн түвшинг шинэ шатанд гаргах, улмаар харилцагчдад найдвартай, соёлтой харилцааг үзүүлэх зорилготойгоор зохион байгуулагддаг онцлог юм.

Тав дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа энэхүү тэмцээнд ХХБанкны 100 гаруй хамгаалалтын ажилтнууд 7-н багт хуваагдан өрсөлдсөнөөс:

**ТЭРГҮҮН БАЙР** Б.Түвшин ахлагчтай мөнгөн зөөврийн бүлэг  
**ДЭД БАЙР** Б.Сайнбуян ахлагчтай II тасаг  
**ГУТГААР БАЙР** Д.Наранбаатар ахлагчтай I тасаг

тус тус эзэлж өргөмжлөл, цом, үнэ бүхий зүйлсээр шагнууллаа. Тэмцээний тусгай байрыг В.Отгонбаатар ахлагчтай III тасаг эзэллээ.

“МАРШ ТАКТИК - 2019” тэмцээн нь хамгаалалтын ажилтнууд бие биеэсээ суралцаж туршлагажсан, албаны ур чадвараа ахиулсан, тэсвэр хатуужил суусан, нийт бүрэлдэхүүний албаны ур чадварын түвшинг дээшлүүлж, ажлын арга тактик, алдаа оноогоо дүгнэж, цэгнэсэн томоохон сургалт боллоо.

**ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА**

<b>АЛТ</b> 1302.90 0.60%	<b>ЗЭС</b> 6431.00 0.42%	<b>10-ЧИНГИС БОНД</b> 98.700 0.13%	<b>ХУРАЛДАЙ БОНД</b> 110.70 0.12%	<b>ГЭРЭГЭ БОНД</b> 99.330 0.12%	<b>АМ.ДОЛЛАР</b> 2631.60	<b>ЮАНЬ</b> 391.63	<b>РУБЛЬ</b> 40.24
--------------------------------	--------------------------------	--	---	---------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

# Улс төр

# “Эрдэнэт”-ийн 51%-ийг “Стандарт” банкинд алдсан хүмүүст хариуцлага тооцох ёстой

**ЖДҮХС-гийн мөнгийг авсан гишүүдэд хариуцлага тооцохыг шаардав**

**Б.Сэлэнгэ**  
ЗГМ

АН-ын дэргэдэх Ардчилсан залуучуудын холбооноос мэдээлэл хийж, зарим асуудлаар эрх баригчдаас хариуцлага нэхлээ. Тухайлбал, “Эрдэнэт” үйлдвэрийн 51 хувийг барьцаанд тавьж, Өмнөд Африкийн “Стандарт” банкнаас зээл авсан, авахад холбогдсон хүмүүст эрх баригчид хатуу хариуцлага тооцох ёстой гэж тэд үзээд байна. “Эрдэнэт” үйлдвэрээр баталгаа гаргуулж гадаадын банкнаас авсан зээлээ төлж чадаагүй буруутай этгээдүүдийн өмнөөс тус үйлдвэр өдөрт зөвхөн зээлийн хүүгийн төлбөрт 100 сая төгрөг, сард нэг сая ам.доллар төлж байгаа. Тиймээс улсад учруулж буй хохирлыг барагдуулахын тулд хууль ёсны дагуу шалгах хэрэгтэй гэж АЗХ-ны тэргүүн С.Эрдэнэболд хэллээ. Мөн ЖДҮХС-гаас 120 орчим



тэрбум төгрөгийг МАН-ын эрх баригч дарга нар ойр тойрныхоо хүмүүст авч өгөн жирийн иргэдийн боломжийг булаасан гэмт хэргийн шинжтэй үйлдэлд хариуцлага нэхэв. Энэ асуудалд Засгийн газрын нэр бүхий сайдууд, 20 гаруй гишүүн оролцсон. Тиймээс Ерөнхий сайд У.Хүрэлсүх “Шударга ёсыг тогтооно” гэж хэлсэн үгэндээ хүрч, “ЖДҮ”-чин гишүүдийнхээ

эрхийг түдгэлзүүлж, шалгуул” гэж сөрөг хүчний залуус шаардав. Саяхан АН-ын зарим залуус мэдээлэл хийж, “Намын удирдлагууд нь МАНАН бүлэглэлийг хамгаалж байна” гэх мэдээллийг өгсөн. Энэ талаар С.Эрдэнэболд “Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нь хүндэтгэж байгаа ч шинэчлэлийн төлөө явж буй намаа бүхэлд нь харлуулж болохгүй. МАНАН бүлэглэл

2004 оноос эхлэлтэй. 2004 онд Ерөнхий сайдын суудлаар эхэлсэн МАНАН, 2008 онд таван хүний эрдэнэт амь эрсэдсэний дараа Шадар сайдын суудлыг тухайн үеийн АН-ын даргад өгснөөр улам бүр бэхжсэн. Ийнхүү урт хугацаанд хоёр намын эрх ашгаар сүлбэлдсэн хүмүүсийн харилцаан дээр МАНАН бий болсон. Өнөөдөр АН-ын залуус МАНАН-гийн аливаа нэгэн

харилцааг залгамжилж авч үлдэхийг хүсэхгүй байна. Мөн үүнээс болж хэн нэгнийг хамгаалж, хэн нэгнийг буруутгахдаа улс төрийн явцуу ашиг сонирхолд хөтөлгөдөггүй байхыг эрмэлздэг. Тиймээс хэн нэгнийг үгүйсгэхийн тулд залуучууд гар хөл болохгүй байхыг уриалж, цаашид АН бодлого суурьтай, үзэл баримтлалтай зарчмаар ажиллана” хэмээв. [ЗГМ]

## ЗГМ ТОВЧХОН

» **МЭДЭГДЭЛ**  
Ерөнхийлөгч Х.Баттулгын Улс төрийн бодлогын зөвлөхийн ажлаа өгч буйгаа мэдэгдсэн Н.Алтанхуяг шалтгаанаа “АН-ын удирдлагатай хариуцлага тооцох хойшлуулшгүй ажил хүлээж байна” хэмээн тайлбарлав.

» **ТОО**

22

Турк улсын Анкара хот дахь хуурай замын цэргийн их сургуульд Монгол Улсаас өнөөдрийн байдлаар 22 сонсогч цэргийн нарийн мэргэжлүүдээр суралцаж байна. Батлан хамгаалахын сайд тус улсад хийсэн айлчлалынхаа үеэр тэдгээр сонсогчтой уулзлаа. Мөн тэрбээр Анкара хотод байрлах Машин Механизм, химийн аж үйлдвэрийн корпорацийн үйл ажиллагаатай танилцав. Тус үйлдвэр нь 1923 онд Батлан хамгаалах салбарын анхны компани болон байгуулагдсанаас хойш бүх төрлийн зэвсэг, сум галт хэрэгслийг үйлдвэрлэсээр иржээ.

## ЭШЛЭЛ



Сүүлийн үед бүс нутгийн хэмжээнд өрнөж буй байлдааны ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөний өрнөл, шинж чанараас үүдэн улс орнуудын батлан хамгаалах асуудалтай холбоотой дэвшигдэн гарч буй шинэ үзэл хандлагуудын нэг бол “Хамтын батлан хамгаалах” судлал болж байна. Дэлхий дахинд аливаа нэг улс дангаараа, бие дааж өөрийнхөө аюулгүй байдлыг хангах, өөрийгөө батлан хамгаалах нь өрөөсгөл агаад сул талтай болох нь нэгэнт тодорхой болжээ. Ийм нөхцөлд цэргийн итгэлцэл, цэрэг техникийн хамтын ажиллагааг бүх хөрш болон бусад орнуудтай бүх талаар хөгжүүлэх нь чухал болоод байгаа юм. *Ерөнхийлөгч Х.Баттулга*

## ЗАСГИЙН ГАЗАР

# Д.Сумъяабазар: “Эко Алтан Заамар”-ын лицензүүдийг цуцалсан

УУХУЯ-наас зохион байгуулдаг “Ил тод уул уурхай” хэвлэлийн хурал болж, орд газруудтай холбоотой зарим асуудалд мэргэжилтнүүд хариуцсан юм. “Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хүрээнд 400 гаруй орд тусгай зөвшөөрлийг цуцлах, улс авах асуудал байхгүй. Компаниуд хуулийн дагуу ажлаа хийж байна” хэмээн АМГТГ-ын дарга хэллээ. 2014 онд УИХ-ын тогтоолоор Цагаан суваргын ордод төрийн эзэмшил 0 байхаар тогтоосон билээ. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордуудын тусгай зөвшөөрөл эзэмшсэн бол өмнөх төлбөрийг тухайн компани нөхөн төлөх үүрэгтэй. Энэ зардлыг төлөөгүй бол тусгай зөвшөөрлийг нь хураан авдаг журам бий. Өнөөдрийг хүртэл хугацаанд ийм зөрчил гараагүй. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулууд бүгд төлбөрөө хуваарийн дагуу төлөвд явж байгаа гэж тэрбээр нэмж хэлсэн юм.

Харин Төв аймгийн Заамар суманд үйл ажиллагаа явуулдаг “Эко Алтан Заамар” компанийн уурхайд гарсан осолтой холбогдуулан тус компанийн үйл ажиллагааг зогсоохоо салбарын сайд Д.Сумъяабазар хэлэв. Тэрбээр “Эко Алтан Заамар” компанийн тусгай зөвшөөрлийг цуцална. Компанийн эзэд ашгийн хойноос хөөцөлдөн, мэргэжлийн бус хүмүүс нь инженерүүдийнхээ зөвлөгөөг сонсдоггүй эздийн гайгаар эрдэнэт хүний амь нас эрдэж байна. Зөвхөн сорчилсон байдлаар олборлолт хийдгийн уршиг энэ юм. МХЕГ-аас бидэнд удахгүй ослын дүгнэлтийг танилцуулна. Осол болохоос нэг өдрийн өмнө тус компанийн 0189 тоот лицензийн талбайд осол гарсан. Нийт дөрвөн тусгай зөвшөөрөл эзэмшдэг компани” гэв. Харин “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувьтай холбоотой асуудлаар Д.Сумъяабазар “Гарц нь талууд хувариан дагуу төлөвд явж байгаа гэж тэрбээр нэмж хэлсэн юм. [ЗГМ]

## СОНГУУЛЬ

# БЗД-ийн сонгуульд дөрвөн намын найман хүн нэрээ дэвшүүлжээ

Баянзүрх дүүргийн 10, 19 дүгээр тойргийн дахин сонгуулийг энэ сарын 23 буюу ирэх бямба гарагт зохион байгуулах юм. Өнгөрсөн 2016 оны аравдугаар сарын 24-нд Баянзүрх дүүргийн ИТХ-ын сонгууль болсон. Тухайн үед 10 дугаар тойрогт нэр дэвшсэн А.Эрдэнэсайхан, 19 дүгээр тойрогт нэр дэвшсэн Х.Өлзийхорол нар нь Сонгуулийн тухай хуулийг зөрчсөн гэж үзэн, Улсын дээд шүүхээс тухайн тойргуудад дахин сонгууль явуулах нь зүйтэй хэмээн шийджээ. Энэ талаар баасан гарагт

нийслэлийн Сонгуулийн хорооны дарга У.Ганболд, Баянзүрх дүүргийн Сонгуулийн хорооны дарга И.Баттөгс нар мэдээлэл хийлээ. Дахин сонгуульд дөрвөн намын найман төлөөлөл нэрээ дэвшүүлжээ. Мөн дөрвөн хүн бие даан нэр дэвшиж буй аж. Өөрөөр хэлбэл, нэг тойрогт зургаан нэр дэвшигч өрсөлдөнө гэсэн үг. Хоёр тойрогт санал авах таван байр байгаа бөгөөд нэр дэвшигчид ирэх лхагва гарагийн 00.00 цагт сурталчилгаага зогсоох ёстой аж. [ЗГМ]

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН МЭНДЧИЛГЭЭ

## Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 98 жилийн ойн баярт

Эрхэм хүндэт генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагчид аа,

Эх орныхоо нэрийн өмнөөс дэлхийн халуун цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчид аа, Бэлтгэлд болон чөлөөнд байгаа ахмад дайчид аа, Эх орны маань нэр төр, сүр хүч, сүлд хийморийн илэрхийлэл болсон зэвсэгт хүчний нийт албан хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэндээ Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 98 жилийн ойн баярын мэндчилгээг алс холын Африк тивийн Өмнөд Судан Улсад үүрэг гүйцэтгэж байгаа цэнхэр дуулгат Монгол цэргүүдийнхээ хамтаар өргөн дэвшүүлж байна. Алс холын оронд, Хубилай хааныхаа алдраар овоглосон цэргийн баазад Монгол цэргүүд дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ нэр төртэй биелүүлж байгаа нь манай зэвсэгт хүчний нэгэн бахархал болж байна.



шантраагүй.

Та бүхэн оролцсон ажиллагаа, үүрэг гүйцэтгэсэн ээлж болгондоо эх орон, ард түмнийхээ нэр төрийг өндөрт өргөж, баатарлаг үйлс, бахархам гавьяа байгуулсаар байна.

Хүлээсэн үүргээ цэрэг хүний ёсоор алдаа мадаггүй биелүүлэн халдлага, дайралт, аюул ослыг сөрөн зогссон жинхэнэ баатрууд Та бүхний дунд хэдэн арваараа зогсож байна.

Монгол Улсын Ерөнхий сайд миний бие гадаад орны төр, засгийн удирдлагатай уулзахад Та бүхнийхээ байгуулсан гавьяа, үйл хэргээр тань ямагт омогшин бахархаж, нүүр бардам зогсдог юм. Энэ эрхийг манай эрэлхэг зоригтой охид, хөвгүүд, энхийг сахиулагчид Та бүхэн бидэнд олгосон билээ.

Та бүхэн энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэнээр Монгол Улсынхаа нэр хүндийг дэлхийн тавцанд улам баталгаажуулж, зэвсэгт хүчнийхээ хөгжил дэвшилд бодит хувь нэмэр оруулж байгаагийн зэрэгцээ улс орныхоо эдийн засаг, аюулгүй байдал, тогтвортой хөгжилд ч шууд болон шууд бус хэлбэрээр ач тусгаа үзүүлж байгааг баярын энэ өдөр би зориуд онцлон тэмдэглэж хэлэхийг хүсч байна.

Миний бие Ерөнхий сайд, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүний хувьд ч, бас цэрэг хүн, офицер хүний хувьд ч, улс орны батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилгот хөтөлбөр, төслүүдийг тууштай хэрэгжүүлж, зэвсэглэл техникийн шинэчлэл хийх, цэргийн алба хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг хангахад тодорхой арга хэмжээ авч, үр дүнд хүргэхийн чухлыг онцлон тэмдэглэж байна.

Монгол цэргийн баярын энэ өдөр байгуулсан гавьяа зүтгэл, шударгаа ариун хөдөлмөрийнхөө үнэлгээ болсон одон медалиараа гоёж, сэтгэл зүрх нь догдлон байгаа ахмад дайчиддаа чин сэтгэлийн хүндэтгэл илэрхийлэн, урт насалж удаан жаргахын ерөөл дэвшүүлэе.

Та нарын маань нугаршгүй ноён нуруу, бүтээсэн алдар гавьяа, дадлага туршлагын их өв сан зэвсэгт хүчний хөгжлийн нэгэн тулгуур багана болсоор ирсэн, цаашид ч байх болно.

Цэргийн хүний гэр бүл зэвсэгт хүчний бат бэх ар тал, ёс суртахууны үндэс суурь нь байдаг. Тэд үнэнч сэтгэлээр, тэсвэр хатуужилтайгаар, ажил амьдралын хүнд бэрхийг хамтдаа даван туулж, их үйл хэргийн төлөө өөрийгөө зориулахын үлгэр жишээ болсон хүмүүс юм.

Амжилт ололт, алдаа оноо бүрийнх нь ард сэтгэл догдлон байдаг цэргийн албан хаагчдын ар гэрийнхэн Та бүхэнд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн талархал илэрхийлэе.

Баатарлаг дайчин уламжлал, бахархам үйлсийн арвин баялаг түүхтэй зэвсэгт хүчний эрэлхэг дайчид Та бүхнийг өнө эртний түүхт Монгол төрийн сүлд хиймөр мөнхөд ивээж явахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлэе.

Монгол цэргийн сүр хүч, цог золбоо үеийн үед мандан бадрах болтугай.

Монгол Улсын төлөө зүтгэе.



## Нийгэм

### ЗГМ ТОВЧХОН

#### » БОЛОВСРОЛ

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн санхүүжилтээр Япон улсад суралцах 98 оюутан “батламж” гардан авлаа. Үүнээс “Коосэнд” 30, бакалаврын хамтарсан хөтөлбөрөөр 52, магистр, докторт 16 оюутан тус тус суралцах бөгөөд оюутнууд энэ сарын сүүлээр Япон улсыг зорих юм байна.

#### » ШҮҮХ

Боловсролын зээлийн сангаас зээл авч суралцаад, төлбөрөө төлөөгүй оюутнуудын асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхээр болжээ. Тодруулбал, тус сангаас зээл авсан 179 оюутан ор сураггүй алга болсон байна.

#### » ЦАГ АГААР

Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн мэдээллээр өнөөдөр баруун болон төвийн аймгуудын нутгаар, маргааш ихэнх нутгаар хур тунадас, нойтон цас орж, цасан шуурга шуурч, эрс хүйтрэхийг онцгойлон анхааруулж байна.

#### » СПОРТ

Олон улсын жүдо бөхийн холбооноос зохион байгуулдаг “Их дуулга” тэмцээн өнгөрсөн баасан гарагт ОХУ-ын Екатеринбург хотод эхэлсэн. Уг тэмцээнд 47 орны 358 жүдоч өрсөлдөж буй бөгөөд Монголын 20 жүдоч оролцож байна. Тэмцээний эхний өдөр 60 кг-ын жинд Л.Өнөболд Марокко, Тайвань, ОХУ, Японы бөхчүүдийг дараалан ялж, аваргын алтан медаль хүртлээ.

#### » НИЙСЛЭЛ

Нийслэлийн газрын албанаас Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Богд хааны ордон музейн эзэмшил хашаан дотор зөвшөөрөлгүй баригдсан нэг давхар барилгыг буулгав.

# Танд орхигдсон зүйлс бусдад чухал хэрэглээ болно

*Өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангана*

**Э.Батцэцэг**  
ЗГМ

Үйлдвэрлэл хөгжихийн хэрээр хог хаягдлаа хаана агуулах вэ гэдэг асуудал тулгардаг. Хүн төрөлхтөн 1970 оноос дэлхийн нөөцийг үндсэндээ шавхаж дууссан гэж үздэг аж. Үйлдвэрлэлийн явц дахь нүүрстөрөгчийн ялгаруулалтаа 30 хувиар бууруулсан ч, 2030 оны есдүгээр сар гэхэд бидэнд дахин нэг дэлхий шаардлагатай болно гэж ногоон эдийн засагчид тооцоолсон. Тэд байгалийн нөөцийн хомсдолыг бууруулж, орчны доройтлын эсрэг, хүний сайн сайхан, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг хангахын төлөөх эдийн засгийн онолыг баримталдаг. 2012 онд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн чуулганаар дэлхий нийтийн тулгамдсан асуудал бол ядуурлыг бууруулах бөгөөд ногоон эдийн засаг гол байр суурийг эзэлнэ гэж тунхагласан нь ирээдүйд тэргүүлэх салбар болгохоор чухалчилсны илрэл юм.

Хүн төрөлхтөн жилд 90 триллион ам.долларын бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж, тэдгээрийн 70 хувийг нь дахин ашиглахгүй хаядаг. Ниймээс гурван “R” (Reuse-дахин, сэргээж ашиглах, Recycle-дахин боловсруулах, Reduce-бууруулах) буюу дахин хэрэглээг амьдралдаа хэвшил болгохыг дэлхий нийтээр уриалах боллоо. Танд орхигдсон, илүүдсэн зүйлс бусдад чухал хэрэглээ болдог тул эдгээрийг холбох зорилготойгоор олон улсад second hand буюу “дахин ашиглах боломжтой эд зүйлс”-ийн дэлгүүрийг байгуулж иргэд хоорондын гүүр болж иржээ. АНУ-д гэхэд л Good will store сүлжээ дэлгүүр хамгийн алдартай бөгөөд улсаас нь татварын хөнгөлөлт үзүүлэн дэмждэг. Харин БНСУ дахь Beautiful store нь мянга гаруй сүлжээ дэлгүүр нээж, иргэдэд хамгийн ойр байхыг эрхэмлэдэг аж. Тэгвэл Монголд үүнтэй нэгэн адил “Мөрөөдлийн гэрэл” эко дэлгүүр байгуулагдаад 20 хонож байна.

Тус дэлгүүрт иргэдийн сайн дураараа хандивласан дахин хэрэглэх боломжтой бараа бүтээгдэхүүнээ гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гар урлалын зүйлсийг хямд үнээр худалддаг. Одоогоор өрх толгойлсон нэгэн эмэгтэй худалдагчаар нь ажилладаг ба хөгжлийн бэрхшээлтэй хоёр туслахтай болохоор зэхэж байгаа юм байна. Энэ хүмүүнлэгийн үйлсэд туслахаар сайн дурын гишүүд өдөр бүр ээлжлэн ирдэг. Их дээд сургуулийн оюутнууд голдуу

байх бөгөөд тэд иргэдээс хандивласан хувцас хэрэглэлийг цэвэрлэж, засаж, шошго зүүгээ худалдахад бэлэн болгож өгдөг юм байна. Мөн сэргээх боломжгүй эд зүйлийг хэлбэр, зориулалтыг нь өөрчлөн дахин ашиглахаар оёдол, засвар хийдэг аж.

Хэдийгээр нээгдээд удаагүй ч хүүхдийн тоглоом хамгийн их зарагджээ. Гэхдээ амралтын өдрүүдээр иргэд гутал, хувцас, тоглоом, ном, гэр ахуйн бараа гээд маш олон зүйл авчирч өгдөг аж. Бараа нь долоо хоногтоо зарагдаж дуусдаг тухай худалдагч бүсгүй ярьж байлаа. Хүмүүс энэ дэлгүүрийн тухай нэгнээсээ сонсдог, мөн фэйсбүүкээс олж мэддэг ажээ. Энхрийнхээ бэлдсэн гурван тортой эд зүйлийг авчирсан залуу, хоёр дахь удаагаа энэ дэлгүүрт ирж байгаа гэсэн. Тэрбээр, “Монголчууд хуучин хувцсаа хүнд өмсүүлэх муу, шатаана, устгана гэдгийг бид тоодоггүй. Манайх гурван хүүхэдтэй, багдсан хувцас, хэрэглэхээ больсон, уйдсан тоглоомуудыг нь авчирч өгдөг юм. Хэрэгтэй нэгэнд нь хүрч л байг” гэлээ.

### Хүүхдийн тоглоом хамгийн их зарагджээ

Барааны хувьд 200 төгрөгөөс 30 мянган төгрөгийн үнэтэй бөгөөд “танд хэрэгтэй бол үнэгүй аваарай” гэсэн бичигтэй хоёр сагсанд зарим зүйлсийг хийжээ. СБД-ийн 13 дугаар хороо буюу 32-ийн тойргоос баруун тийш 500 метр газарт “Мөрөөдлийн гэрэл” эко дэлгүүр байрладаг. Зорилтот бүлэгтэй ойр байх үүднээс гэр хороололд түрээсийн байранд нээсэн дэлгүүрээ цаашид олон салбартай болгох зорилготой гэсэн.

БНСУ-д ажиллаж амьдардаг найман залуу нэгдэж, энэ дэлгүүрийг нээжээ. Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, өрх толгойлсон эмэгтэйчүүд,



ЗГМ

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих гол зорилготой гэж тодорхойлсон уг ажил нь өдгөө байгаль орчныг хамгаалах, дахин хэрэглээг нэвтрүүлснээр нөөц хомсдолыг бууруулах, ногоон эдийн засгийг дэмжих эко сэдлээр дахин ашиглахаар оёдол, засвар хийдэг аж. Хэдийгээр нээгдээд удаагүй ч хүүхдийн тоглоом хамгийн их зарагджээ. Гэхдээ амралтын өдрүүдээр иргэд гутал, хувцас, тоглоом, ном, гэр ахуйн бараа гээд маш олон зүйл авчирч өгдөг аж. Бараа нь долоо хоногтоо зарагдаж дуусдаг тухай худалдагч бүсгүй ярьж байлаа. Хүмүүс энэ дэлгүүрийн тухай нэгнээсээ сонсдог, мөн фэйсбүүкээс олж мэддэг ажээ. Энхрийнхээ бэлдсэн гурван тортой эд зүйлийг авчирсан залуу, хоёр дахь удаагаа энэ дэлгүүрт ирж байгаа гэсэн. Тэрбээр, “Монголчууд хуучин хувцсаа хүнд өмсүүлэх муу, шатаана, устгана гэдгийг бид тоодоггүй. Манайх гурван хүүхэдтэй, багдсан хувцас, хэрэглэхээ больсон, уйдсан тоглоомуудыг нь авчирч өгдөг юм. Хэрэгтэй нэгэнд нь хүрч л байг” гэлээ.

хандив авах нь хэрэглэгчдэд илүү хямд хүрэх эерэг талтай байв. Дэлгүүрийн нээлтэд санаачлагч залуусын хүүрээлэл оролцсон бөгөөд 735 мянган төгрөгийн борлуулалтын орлого, 1.04 сая төгрөгийн хандив, мөн БНСУ дахь “Ногоон Ази” ТББ-ын 11.5 сая төгрөгийн хандивыг тус тус хүлээн авчээ. Санхүүгийн тайлангаа ил тод мэдээлж, илүү олон салбартаа өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэхээ тус ТББ-ын тэргүүн хэлнэ лээ. Дэлхийн 40 гаруй оронд хэвлэгдэж, New York Times

сонинны бестселлэрээр шалгарч байсан Мари Кондо хэмээх япон бүсгүйн номын эхний хэсэгт өөрт хэрэгцээгүй зүйлсээсээ салах тухай өгүүлдэг. Ервобын орнуудад ихэд түгсэн эмх цэгцтэй амьдралын хэвшлийг монгол эзэгтэй нар хэрэгжүүлж эхлээд буй. Хэзээ нэгэн цагт хэрэг болж магадгүй гэж хадгалсан хувцас хэрэглэл шүүгээнд чинь тоосонд дарагдаж байхын оронд “Мөрөөдлийн гэрэл” эко дэлгүүр зэрэг дахин хэрэглээг дэмжих төслийн ачаар хэрэгтэй нэгэнд нь очвол хадгалснаас илүү сэтгэлийн баяслыг танд авчрах буй э. Та ч гэсэн туршаад үзээрэй. [ЗГМ]

## [ЗГМ СӨНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга  
**Эрдэнэбаатарын ДОЛГИОН**

Ерөнхий эрхлэгч  
**Баатарын ДУЛАМХОРЛОО**

Зөвлөх  
**Шатарбалын ДАВААДОРЖ**

Орлогч эрхлэгч  
**Лхагважавын СУГАРМАА**  
Утас: 99903584

**РЕДАКЦ**

Улс төр, нийгэм, эрэн сурвалжаах мэдээллийн алба  
**Эдитор Б.Энжжаргал**  
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба  
**Эдитор Г.Баярсайхан**  
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба  
**Эдитор З.Цэцмэг**  
Утас: 99901526

**ЗАР СУРТАЛЧИЛГАА**

Утас: 99903581  
99903578  
99907843

**ХАЯГ**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,  
“Бло Скай тауэр” 407 тоот  
Улсын бүртгэлийн дугаар: 1024  
Утас: 70103131,  
Факс: 7010606

**ЦАХИМ ХУВИЛБАР**

zg.mn  
ubinfo.mn  
Дугаарын удирдагч  
Л.Сугармаа



### “Нойрны төв” долоо хоногт гурван хүнд үйлчилнэ

Сүүлийн жилүүдэд нойргүйдлээр өвчлөх иргэдийн нас залуужсаар байна. Тиймээс нойрны өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор Нойрны төвийг байгуулжээ. Тус төв нь нас харгалзахгүйгээр нойрны өвчнийг оношилж, тогширох эмчилгээ бичиж өгөх аж. Мөн төрийн тусгай алба хаагчид харьяаллын дагуу хэвтэн эмчлүүлэх боломжтой.

Харин оношилгоонд хамрагдах иргэн эрүүл мэндийн даатгалаараа

165 мянган төгрөг хөнгөлүүлж, эмнэлгийн кассанд 25 мянган төгрөг тушаагаад үйлчлүүлэх боломжтой аж. Нойрны төв нь долоо хоногт гурван хүн оношлох боломжтой бөгөөд иргэд үйлчлүүлдээ урьдчилан цаг авах шаардлагатай. Тус төв нь нойрны өвчлөлийн бүх төрлийг оношилж, эмчлэх бүрэн чадвартай. Тухайлбал, хурхирах, нойрон дундаа амьсгал тасалддаг эмгэгтэй хүмүүсийг тогтмол агаарын аппаратаар эмчлэх юм. [ЗГМ]

## ХӨТӨЛИЙН “ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

### ХӨТӨЛИЙН “ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 дугаар сарын 24 -ны өдрийн Даваа гарагийн 11.00 цагт “Цемент Шохой” ХК-ийн өөрийн байр, Хурлын танхимд болно.

#### ХААНА

Сэлэнгэ аймаг, Сайхан сум, 1-р баг, “Цемент шохой” ХК-ийн өөрийн байр, Хурлын танхим

#### ХЭЗЭЭ

2019 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 11:00 цагт

#### ХУРАЛД ОРОЛЦОХ ЭРХТЭЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ ГАРГАХ БҮРТГЭЛИЙН ӨДӨР:

2019 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр

#### ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

Компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;  
Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, томилох тухай Компанийн ногдол ашгийн талаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;  
Бусад.

#### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Комиссын дарга: Б.Ариунтунгалаг  
Комиссын гишүүд: А.Сосорбурам  
Б.Соёл-Эрдэнэ

Хурлын материал, гаргах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд /Даваа-Баасан/ 09-17 цагийн хооронд Хөтөлийн “Цемент Шохой” ХК-ийн байранд Гүйцэтгэх захирал А.Шоовдор болон комиссын гишүүдээс хүлээн авч танилцах боломжтой.

**Холбоо барих: Утас: 70368151,  
Факс: 7036-8368**

**И-мэйл хаяг: info@khutulcement.mn**

# ЗГМ: Сэдэв

## Өндөр татвар бизнесийн орчны хамгийн том бэрхшээлээр нэрлэгдэв

Г.Билгүүн  
ЗГМ



С.Батсайхан / ЗГМ

АТГ том "тул"-аа хүчрэхгүй, "жараахай" бүрийг хөөж амжихгүй байгаа тул гүйцэтгэх засаглалын тэргүүнд хандахаас аргагүй.

олон хүн хэлнэ. АТГ том тулаа хүчрэхгүй, жараахай бүрийг хөөж амжихгүй тийм л байдалаар ажиллаж буйг түмэн олон мэдэж байгаа хойно гүйцэтгэх засаглалыг барьж буй Ерөнхий сайдад хандахаас аргагүй. Азийн сангийн энэ судалгаа бол нийгмийг хамарсан том судалгаа биш ч гэсэн хөндлөнгөөс хийсэн, төрд долигоноогүй, бизнес эрхлэгчдэд чиг заахдаг "суурь" судалгааны нэг учраас бодитой үр дүнг үүгээр шүүж болох мэт. Ядаж л бизнес эрхлэгчдийн дуу хоолойг тод сонсохын тулд энэ судалгааны үр дүнгээр төрийн зарим байгууллагын ажлыг дүгнэж болмоор. Ялангуяа, авлигад их өртсөн нэр зүүж хар жагсаалтыг манлайлж буй татвар, мэргэжлийн хяналт, гааль, цагдаа, газар, кадастрын албаны ажлын


# Бизнес эрхлэгчид мэргэжлийн хяналтыг авлигад хамгийн их идэгдсэн гэв

Монгол Улсын дэлхийд өрсөлдөх чадварын индекс 124-өөс 101-т дэвшиж сайжирсан ч төсвөө үр ашиггүй зарцуулдаг орнуудын жагсаалтад эхний аравт багтсан хэвээр байгаа нь төрийн албанд авлига их байдагтай шууд холбоотой.


Азийн сангаас жил бүр бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын судалгаа хийдэг. Түүгээр бизнес эрхлэгчид өөрсдөд учирсан "зовлон"-гоо илэрхийлдэг болсоор өдгөө гурван жилийн нүүр үзэж байна. Тус судалгаагаар бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд саад учруулж буй төрийн байгууллагуудын жагсаалтыг ч гаргадаг юм. Түүгээр татвар, мэргэжлийн хяналт, гааль, орон нутгийн захиргааны байгууллагууд хамгийн их гай болдог талаар 330 компанийн удирдах түвшний ажилтнууд дуу нэгтэй хариулжээ. Сүүлийн гурван жилийн байдлаар татварын газар энэ жагсаалтыг тасархай тэргүүлж байгаа нь бизнес эрхлэгчдэд татварын дарамт их байдгийн тод илрэл юм. Төр оршихын тулд татвар байх нь тодорхой боловч татвар авахдаа бизнесийг боомилж болохгүйг мяндагтан, мундгууд ойлгоогүй л байна. 2018 онд бизнесийн орчинд тулгарсан хамгийн гол бэрхшээл "өндөр татвар" гэж энэ салбарынхан мэдэгдлээ. Үүнийг татварын хуулийн шинэчлэлээр удахгүй засна хэмээн "тайвшруулах тариа" хийснээс хойш багагүй хугацаа өнгөрч буй. Татварын багц хуулийг парламентаар хэлэлцэхээр аль эрт өргөн барьсан ч суудлын хэрүүл, суулт тэмцлээс шалтгаалж он дамначхаад байгаа нь бизнес эрхлэгчид татварын дарамтаасаа илүү бэрхшээл болчихоод байна. УИХ-аар татварын багц хуулийг батлахын тулд өргөн барьсан гурван хууль болон дагаж 29 хууль, 45 эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахаар хүлээж байна. Үүнээс харахад бизнесийн орчинд эрх зүйн зохицуулалт ямар дутмаг байсныг төвөггүй ойлгох биз ээ. Мөн хууль батлагдмагц 18 мянган ААН 36.8 төрбум төгрөгийн шууд хөнгөлөлт эдлэхээр хүлээж байгаа нь татварын дарамт хэр байгааг мөнгөн утгаар илэрхийлж байгаа хэрэг.

"Хар жагсаалт"-ын удаах байранд тусгай зөвшөөрөл, лиценз олголтын шат дамжлага нэрлэгдэж бизнесийн орчинд саад учруулагчаар тодорсон. 2016 онд бизнес эрхлэгчдийн 17 хувь нь тусгай зөвшөөрөл

### Бизнес саад учруулж буй тэргүүлэх төрийн байгууллага



### Авлигад хамгийн их өртсөн байгууллага



"проблем" болж байсан гэсэн бол энэ үзүүлэлт 2017 онд 22.4, өнгөрсөн жил 24.8 хувь болж өсжээ. Нэгэнтээ Ерөнхий сайд олон цаас урж, хогийн саванд хийснээс хойш энэ чиглэлийн бичиг баримт бас л хуримтлагдсан байна.

Төрийн албан дахь авлигад хамгийн их өртсөн байгууллагын жагсаалтад гаалийн алба сүүлийн гурван жил дэд байранд баттай зогсоор байна. Бизнесийнхэн эргэлтээ нэмэхийн тулд гаалийн байгууллагын шат дамжлагыг товчлохыг хүсдэг. Энэ нь авлигад хүүрэх хөшүүрэг болдгийг хэн үгүйсгэх вэ. Импорт зонхилсон худалдааны байгууллага гаалийн

бүрдүүлэлт, ачаа тээврийн аюулгүй байдал зэргээс эхлээд гаалийнхныг царайчлах зүйл мундахгүй. Гуйна гэдэг гутамшигт тооцогддог болохоор гутамшигтай арга замаар ажлаа бүтээхээс аргагүйд хүрдэг биз. Тиймгүйсэн бол энэ салбарын 330 саналын дийлэнх нь гааль авлигад их өртсөн гэж жил дараалан хариулахгүй байх сан. Энэ жил Засгийн газраас гаалийн албаны шинэчлэлийг хийж, бараа эргэлтийн хурдыг нэмэхээр амлаад буй. Техник, технологийн шинэчлэл хийлгүй олон жил гаалийн байцаагчийн нүдээр "ажилласан" энэ салбар хамгийн их хардлагад өртөх нь зүй. Үүнийгээ ч сайн ашигласан биз. Харин гаалийн шинэчлэлийн дараа тэднийг жагсаалтад сүүд мушгиарай хэмээн өрөө.

Бизнесийн орчинд авлигад хамгийн их өртсөн байгууллагууд хэл амнаас гарахын тулд ямар ажил зохиодгийг сураглавал семинардаж, сэм найрдаад тардаг тухай л ойлголт олон нийтийн дунд бөх оршоор байна. Үүнийг "Төрийн албан дахь авлига таны бизнест хэр нөлөөлдөг вэ?" гэсэн асуултад 79 хувь нь тодорхой хэмжээнд болон маш их гэж хариулснаас харахад ойлгомжтой. Төр авлигачдаасаа салж чадахгүй байгаа нь бизнес эрхлэгчдэд муугаар нөлөөлж, цаашилбал хөгжлийн хурдыг сааруулагч болж буй нь дамжиггүй. Мөн монголчууд авлигыг хүлээн зөвшөөрсөөр байгаа нь гадаадын хөрөнгө оруулалтыг бууруулахад бодитой хүчин зүйл болж байгааг энд дурдахад ер илүүдэхгүй.

Бизнес эрхлэгчдээс "албан бус татвар" нэхдэг байгууллагын тоонд шүүх, цагдаа, шийдвэр гүйцэтгэх байгууллага орж байгаа нь бизнес анхаарал татна. "Хар жагсаалт"-ын эхний тавд дээрх байгууллагуудыг

нэрлэсэн нь нэгийг өгүүлж байна. ААН-үүдийн 35 хувь нь эдгээр байгууллага авлигад их өртсөн гэж мэдүүлсэн нь жижгүүд ч "хонгил"-оор ордог гэдгийн харуулт биш гэж үү.

## Бизнес эрхлэгчид мэргэжлийн хяналтынхныг авлигад хамгийн их өртсөн гэв

Цагдаагийн хурандаа нар ч эх захгүй баяжсан жишээ дуулсаар байгаа. Төсвийн цалингаар хэр

хөрөнгө цуглуулж болохыг хэн хүнгүй мэдэх тул тэднийг бизнес эрхлэгчдийг дарамталсан гэж хардах үндэслэл дүүрэн. Бизнесийн аль ашигтай салбарт цагдаагийн албан тушаалтнууд монополийг тогтоож байгаа гэсэн яриа гарсан нь ч үүний нэг тал. Төрийн нэрийг барьж бизнесийг нь булаадаг, хувь хүртээхгүй бол хэрэг тохдог байхыг ч үгүйсгэхгүй. Ийм нөхцөлд хууль, хүчний байгууллагад ямар бизнесмэн хандаж далан булчирхайгаа тоочих вэ.

Үүний нөгөө талд АТГ-ын ажилд ахиц гарахгүй байгааг тодорхой харуулчихлаа. Одоогийн үйлчилж буй авлигын эсрэг хууль, тогтоомж бизнесийн орчныг ил тод авлигагүй болгоход үр дүнгээ өгч чадахгүй байгааг

нэг үзүүлэлтийг үүгээр тогтоож, удирдлагатай нь хариуцлага тооцож яагаад болохгүй гэж. Ядаж л эхний гуравт жагссан төрийн байгууллагын удирдагыг шууд халдаг болчихвол хэн бизнесийнхнийг дарамталсан гэдгээр ажлаа өгөхийг хүсэх вэ дээ. Цаашлаад төрийн зүгээс бизнесийг дэмжих, авлигатай тэмцэхэд бодитой ажил болох биш үү. Аливаа зүйл яаж ч муудсан сайжрах тал руугаа явж байр бизнесмэн хандаж далан муу зүйл гэж байж таарахгүй тул засах цаг нь тулсан. Тиймээс Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн "Төрд хууль гэж байдаг юм шүү гэдгийг хууль завхруулж байгаа хүмүүст ойлгуул. Яс маханд нь мэдрүүл" гэсэн алдартай үгээр энэ сэдвийг нээлттэй үлдээе. [ЗГМ]

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** "Гашуун сухайт авто зам" ХХК-ийн Шалган нэвтрүүлэх цэг-2-ын цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах 65 кВт-ын нарны цахилгаан станцын зураг төсөл, барилга угсралтын ажил  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** ЭМГЛ/201901016

"Эрдэнэс Монгол" ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос "Гашуун сухайт авто зам" ХХК-ийн Шалган нэвтрүүлэх цэг-2-ын цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах 65 кВт-ын нарны цахилгаан станцын зураг төсөл, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг 100.000 /нэг зуун мянган/ төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

### 1. Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны жилийн дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас доошгүй байна.

### 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.

### 3. Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын аль нэг жилийн дүн нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.

Тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх. Үүнд:

### Эрчим хүчний яамны:

- 0.1-5 МВт-ын Эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ
- 0.4-10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл
- Мөн ЦДАШ, дэд станцын зураг төсөл боловсруулах байгууллага нь ЦДАШ, дэд станцын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөл

Тендерийн хамт 10.000.000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх "эрхгүй".  
Дотоодын давуу эрх "тооцохгүй".

### "Эрдэнэс Монгол" ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,  
Чингисийн өргөн чөлөө-15, Моннис цамхаг, 14 давхарт  
Утас:97171505

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.03.18

### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ЗУХАГ/2019/01

Харилцаа холбооны зохицуулах хороо нь эрх бүхий тендерт оролцогчдоос "Шатахуун нийлүүлэх" тухай битүүмжилсэн тендерийг ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50'000 төгрөгөөр худалдан авах ба үнийг Голомт банкны 1102626829 тоот дансанд шилжүүлнэ. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт ирүүлж буй тендерийн үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 10:00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 10:30-д нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй  
Сонирухсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Харилцаа холбооны зохицуулах хороо  
Метро бизнес төв А корпус 5 давхар  
Сүхбаатарын гудамж-13  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14201-0033  
Утас:11-304258 Факс:327720.  
Вэб хаяг: www.crc.gov.mn; info@crc.gov.mn

## Технологи

# ДЭЛГҮҮРТ ХЭРХЭН ХЭСДЭГИЙГ ГАР УТАС ТАНЬ ХЭЛЭЭД ӨГНӨ



Ухаалаг утас болгонд эзэмшигчийнхээ байршлыг мэдээлдэг долоогоос доошгүй аппликэйшн ажиллаж байна.

Г.Очирбат  
@ochirbat\_ZGM

Гар утасны байршлыг энгийн аргаар тодорхойлох замаар дэлгүүр, супермаркетын үйлчлүүлэгчдийн худалдан авах хүсэл сонирхлыг оновчтой тодорхойлж болж байгааг CNBC мэдээллээ. Ингэж тодорхойлохын тулд ухаалаг утсанд хэрэглэгчийн байршлыг мэдээлдэг тусгай программ суулгах шаардлагагүй, бүх зүйл хууль ёсны дагуу, ил тод өрнөнө.

Эдүгээ ухаалаг утас хэрэглэдэг хүн бүр цаг агаарын мэдээнээс эхлээд төрөл бүрийн мэдээлэл хүлээн авах үйлчилгээ ашиглаж, байршлынхаа координатыг бусадтай хуваалцдаг болжээ. Шинэхэн стартап Cosmose компаниас БНХАУ-д явуулсан судалгаанаас үзвэл хэрэглэгчдийн ухаалаг утас болгонд эзэмшигчийнхээ байршлыг мэдээлдэг дор хаяж долоон аппликэйшн ажиллаж байна.

Cosmose бол Хятад дахь 100 мянга гаруй дэлгүүрт үйлчлүүлж буй ухаалаг утас эзэмшигчдийн байршлын мэдээлэл нийлүүлдэг

гол компанийн нэг. Ийм мэдээлэл нь нийтдээ нэг тэрбум орчим гар утсыг хамарч байгаа юм.

Цуглуулсан мэдээллээ Burberry, L'Oreal, Subway, Budweiser зэрэг нэр хүндтэй брэндүүдэд борлуулдаг Cosmose нь хэрэглэгчдийн privacy буюу өгөгдлийн халдашгүй байдлыг зөрчдөггүй. Тус компани ердөө лангуунаас лангуу дамжиж буй ухаалаг утасны байршлын координатын мэдээллийг дамжуулдаг.

Байршил тодорхойлох нарийвчлал маш сайн буюу 1.8 метрийн радиусаар зөрөх магад-

лалтай нь худалдан авагч хувцас өмсөж үзэх бүхээг, мөнгө тушаах кассын алинд очсоныг алдаагүй тодорхойлоход хангалттай мэдээлэл болж өгдөг.

Ийм мэдээлэл нь дэлгүүрээр үйлчлүүлэгч ямар бараа бүтээгдэхүүнийг илүү сонирхоод байгааг олж тогтооход тустай. Том компаниуд Cosmose-оос худалдан авсан мэдээлэлдээ тулгуурлан зар сурталчилгааг яг зөв хэрэглэгчдэд нь чиглүүлэн үр дүнтэй өрнүүлж чаддаг ажээ. Дэлгүүрт санаандгүй тохиолдлоор орсон хүмүүс ийм системийн ачаар худалдан

авагчдын эгнээнд шилжиж байгаа нь БНХАУ-ын туршлагаар нотлогдож байгаа юм.

Хятадын зах зээлд асар их амжилт олсон Cosmose дараагийн байгаа АНУ-аар сонгожээ. Ухаалаг утасны байршлын мэдээллийг АНУ-д 75 орчим компани цуглуулж, 200 сая ширхэг дивайсын координатыг тодорхойлж байна. Google, Facebook зэрэг интернэт аваргууд хүртэл ийм мэдээллийг худалдаж мөнгө болгохыг эрмэлздэг. Ухаалаг утасны байршил тодорхойлж зар сурталчилгаа өрнүүлдэг зах зээлийн нийт үнэлгээ энэ жил 21

тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй нь дэлгүүрээр хэсэгчдийг ахиу "мөрдөх" ёстойн шалтгаан болж байна.

Anonymity буюу хэн болохоо нууцлахыг хичээдэг хэрэглэгчид эдүгээ "цаадуул чинь тэртээ тэргүй мэдэж байгаа" гэсэн хайхрамжгүй байр суурьтай болцгоосныг зах зээлийн шинжээчид анхааруулав. Орчин цагийн хэрэглэгчид худалдаа наймаа хийхэд амар дөхөм байхын төлөө privacy буюу хувийн өгөгдлийн халдашгүй байдлыг золигт гаргаж, анзаарахаа ч больж эхэллээ. [ЗГМ]

## Huawei шинэ үйлдлийн системтэй болно

БНХАУ-ын Huawei компанид зах зээлийн тун таагүй нөхцөл бүрдүүлсэн АНУ-ын дарамт шахалт эдүгээ хүртэл үргэлжилж байгаа төдийгүй эрчээ улам авсаар. Ухаалаг утсыг нь АНУ-ын зах зээлд борлуулахыг хориглосон ч Huawei 2018 онд Apple-ыг шахаж бүтээгдэхүүн нийлүүлэлттэй дэлхийд хоёрдугаарт ордог болсон.

Тус компани Huawei Mate 20 загвараа гаргаснаас хойш зээлд уг цувралыг хэдийн 10 сая гаруй ширхэг борлуулаад байгаагаа twitter-ээр дамжуулан мэдэгдлээ. Huawei 2018 онд нийт 200 сая ширхэг утас зарсантай харьцуулах юм бол уг тоо бага санагдаж магадгүй. Гэхдээ дотроо дөрвөн загвар бүхий Mate

20 цувралыг ердөө өнгөрсөн 10 дугаар сарын 20-нд зах зээлд гаргасныг харгалзах юм бол уг тоо тун өөдрөг статистик болж байна. Хожим гарсан Mate 20 Lite загварын борлуулалт ч сайн байх төлөвтэй.

Huawei компанийн хувьд АНУ-ын ухаалаг утасны зах зээл анх эспертүүдийн таамаглаж байсан шиг амин чухал биш бололтой. АНУ-ын аварга зах зээлийг алдсан хохирлоо тус компани бусад улсын зах зээлд төвлөрөх замаар нөхөх боломжтой. Гэхдээ энэ нь АНУ-ын зах зээлээс бүрэн татгалзана гэсэн үг биш. Huawei одоо ч АНУ-ын олон компанигай нягт хамтран ажиллаж байгаа.

Huawei-гийн хэрэглэгчийн салбар хариуцсан гүйцэтгэх



захирал Ричард Ю саяхан Die Welt-д ярилцлага өгөх үеэрээ АНУ-ын Qualcomm, Microsoft, Google-ыг гол түншээ хэмээн нэрлэж байв. Ялангуяа Android үйлдлийн системийг хөгжүүлэгч Google компанитай харилцаагаа таслах нь Huawei-гийн бизнест ноцтой хохирол учруулна.

Харин тэд Qualcomm-ын чипээс хамааралтай байдалаа аль болох багасгах сонирхолтой. Эдүгээ Huawei компани Qualcomm-ын чипийг зөвхөн дунд ангиллын бүтээгдэхүүндээ ашиглаж, дээд зэрэглэлийн үнэтэй загваруудаа өөрийн Kirin процессортойгоор зах зээлд гаргадаг.

Android үйлдлийн системээс татгалзах тухай яриа байж таарахгүй ч Huawei ком-

пани бусдаас хамааралгүй, өөрийн гэсэн үйлдлийн систем хөгжүүлж эхэлснийг ноён Ю мэдэгдлээ.

"Бид өөрийн үйлдлийн систем бүтээв. Бидний хувьд одоогийн платформуудыг ашиглах аргагүй нөхцөл үүсэхэд бэлэн байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл нөөц төлөвлөгөө гэсэн үг. Гэхдээ бид Google, Microsoft-ийн экосистемтэй ажиллахыг аль болох хичээнэ" хэмээн захирал өгүүлэв.

Huawei компанийн мобайл үйлдлийн системийн тухай мэдээлэл 2018 оны эхээр анх гарсан юм. Уг үйлдлийн систем нь Android-д суурилсан, нээлттэй платформ байх болно хэмээн хэвлэлүүд таамаглаж байна. [ЗГМ]



Спорт дрон нисгэгчдийн авхаалж самбааг сорих чухал тэмцээн энэ жил дэлхийн үзэгчдэд үнэ төлбөргүй хүрэх гэж байна. DRL буюу Дроны Уралдааны Холбоо хэмээх олон улсын спортын холбоо дөрөв дэх улирлын тэмцээнээ наймдугаар сарын 11-нээс Twitter болон БНХАУ-ын Youku видео сервис ашиглан шууд дамжуулна. Холбооны шийдвэрийн ачаар технологийн спортын тэмцээнийг АНУ-ын NBC телевизийн сүлжээ, NBCSN спорт сувгийн захиалагч нар төдийгүй хүссэн хүн бүхэн үнэгүй үзэх юм.

Дроны уралдаанд дурлах хүмүүсийн сонирхлыг NASCAR-ын түвшинд хүргэх хүсэлтэй тус холбоо өмнөх гурван улирлын тэмцээнийг ESPN, Sky, Disney-н захиалгат хэрэглэгч, төлбөр бүхий онлайн телевизийн үйлчилгээний хэрэглэгчдээр хязгаарладаг байлаа. DRL дижитал спорт үзэгчдийн цар хүрээг тэлэх зорилгоор хуучин байр

сууриа өөрчилснийг тус холбооны гүйцэтгэх захирал Николас Горбачевски мэдэгдлээ. "Дроны уралдааныг гол стриминг платформуудаар үзэх боломжгүй байгаад DRL-ийн хорхойтнууд сүүлийн гурван жилийн турш гомдол тавьж ирсэн"-ийг захирагч дурдлаа. Twitter нь DRL-ийн уралдааныг хэлэлцдэг гол платформ болж хувирсан учраас дээрх шийдвэрийг гаргасныг Горбачевски нэмж тайлбарласан юм.

Дөрөвдүгээр улирлын тэмцээн нийт 44 цагийн нэвтрүүлэг болно. Агаар, сансрын нислэгийн Lockheed Martin компани ивээн тэтгэдэг тэмцээнд оролцогчид 130 километр/цаг хүртэл хурдлах чадвартай дроныг олон хаалга, нарийн хонгил дамжуулан нисгэж ялагчаа тодруулна. Энэ улирлын тэмцээнд хиймэл оюун ухаан оролцох тул өмнөхөөсөө ч онцгой содон. Тэмцээний тэргүүн байр 200 мянган ам.долларын шагналттай. [ЗГМ]

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо: 2019 оны 03 дүгээр сарын 18-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: **ДХХА гүйцэтгэх механизм нийлүүлэх**  
Тендер шалгаруулалтын дугаар: **МС-2019/058-01**

**"ДЦС-4" ТӨХК** нь эрх бүхий тендер оролцогчдоос ДХХА гүйцэтгэх механизм нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендер оролцогч нь тендер илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. (2017 он, 2018 он)
- 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- 3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил:** Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онд ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт 2% үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө. Тендерийг **2019 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн 10.00 цагаас** өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд ирүүлэх эрхгүй.  
Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцохгүй.  
Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж,  
"ДЦС-4" ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357**

# ZGM DAILY

## ZGM: HIGHLIGHTS

### POLITICS

Minister of Defense Enkhbold Nyamaa pays an official visit to the Republic of Turkey on March 13-15.

Ambassador of Mongolia to the Russian Federation Delgermaa Banzragch attends the 26th MITT-Moscow International Travel & Tourism Exhibition in Moscow. Representatives of foreign tour operators and Russian citizens expressed interested in the promotion of Mongolian companies.

Ambassador of Mongolia to the Republic of Uzbekistan Battulga Luvsan presents his Letter of Credence to the Minister of Foreign Affairs of Uzbekistan Abdulaziz Kamilov.

### ECONOMY

As of February this year, mining and heavy industry sector accumulated MNT 478 billion to the state budget as taxes, fees, and royalties, with an increase of 35.1 percent or MNT 124 billion as compared with the same period of the previous year.

According to Erdenes Mongol LLC, about 400 coal trucks need to enter Gashuunsukhait border to reach coal export target of 42 million tons this year.

### SOCIETY

Mongolian judoka Unubold Lkhagvajamts claims the gold medal in the 60kg weight range at the Grand Slam-Ekaterinburg-2019 competition held by the International Judo Federation in the Russian Federation.

# Ulaanbaatar's standpoint on Trump-Kim Summit

*Xi Jinping is preventing the two countries from merging into one*

Bayarkhuu Dashdorj  
Prof.

The only remainder of the long-persisting conflict after the Cold War is the North Korean peninsula. The war ended in 1953, but no peace agreement was concluded in this particular region for 66 years. This pitiful scene makes me wonder why they collected so many soldiers and weapons in such a small area.

### KIM JONG-UN'S ACHIEVEMENT

The second summit of the North Korea-U.S leaders did not bring expected results, leaving the world in mistrust. Trump's plan to have faith in Kim and perform a political show has failed this time. North Korea shut its door on the U.S because Trump had promised to flourish capitalism in the northern part of the Korean peninsula, which means their social institution (70 years of uncompromising labor), communist ideology, and the great power of Kim would be denied. It may just be because the "communist capitalist" Vietnam, which had been under war for a long time, was chosen for the venom to be seen as a living example to demotivate North



Koreans. The world was left with a question if Vietnam induced North Korea that it is possible to develop a market economy and liberate a market under the strict control of a communist party.

It is unfortunate that Ulaanbaatar was not selected as the venue for the North Korea - U.S summit. Initially, when the officials of the two sides were holding a secret meeting, North Korea proposed to host the summit in Pyongyang, but the U.S did not accept it. It was reported that Mongolia and its capital Ulaanbaatar was selected as the best possible option for the meeting.

It is easy to explain why Ulaanbaatar was not selected as the venue. The current air and environmental pollutions, political instability,

corruption of its authorities, weak financial discipline, poverty, and frustration of Ulaanbaatar are the key downside factors. We can invite anyone, but we need to be diligent and patient. I hope it would be a reminder to us.

I want to praise Kim Jong-un. His autobiography is not uncommon, but also very ordinary. If you try to write a CV, it will not even fill a page. He is not well known in the world except his two meeting with Trump and a few visits to China.

And the main thing to praise is that this young leader is the one who wrote his name on Korean history by fulfilling his father and grandfather's dream to make a straightforward deal with the United States.

In general, Russians are making logical conclusions that being helped by the western countries will completely destroy a country's social regime.

### NORTH'S FURTHER ACTIONS

Two Koreas have worked together with the United States and China in hopes to end the Korean War of the 1950s and establish constant peace and stability. Steady and persistent peace cannot be established, but the first steps were already made. Stages of the weaponry and warfare have discontinued, the two countries stopped their hostile activities, renewed their borders, established border crossings, and sought to seek multilateral negotiations. The world is waiting for the opening of the railroad and the road connecting the two Koreas.

and the main form of advertisement was shown". Some Russian publications were writing that the Russian-Chinese issue was likely to arise as a result of the Korean peninsula dispute.

According to the Russians, the Chinese leader Xi Jinping is preventing the two countries from merging into one. If Kim and Trump become comrades, they will create a new "communist capitalist Korea" in the north and confiscate their weapons, but that weapon is an instrument necessary for holding the United States. Although Pyongyang's leader is difficult to read, he listens to what Beijing says. Once in the past, China has fought for North Korea's independence and has suffered a great deal. Therefore, the Russian authorities and researchers predicted that China will not be happy with the integration.

If Westerners use their money to stop nuclear weapon proliferation, China will pay more money than they could. It will be enough for China to abolish the sanctions against Pyongyang.

Moreover, Russians are worried about what will happen next. It is good for two Koreas to have a network as much as possible. It is a waiver for war. If it is overtaken by the West and rescind China's political support, the process will turn very easily. North and South Korea's overwhelming relation will doubt the U.S, and its faith will decline.

Consider the statement of Russian press about Trump changing his position and views three times a day, which will directly affect the Korean issue. When the reservoir is canceled, the South's investment will start to crush and start integration. It means North Korea's USD 3 trillion mineral wealth, mine, and a huge workforce that is efficient to the South will be in circulation. However, in the Chinese experience, perestroika must be done so as to not imitate the Soviet Union.

If China's reforms are made in the DPRK, Russia will have a lot of opportunities. No Korean railway project can be implemented without Russia. If Russia and China take part in North Korea's "perestroika", the West will not take the lead. [ZGM]

### THE SCANDAL AROUND THE FIRST SUMMIT

The whole world paid attention to the day that Trump and Kim's meeting took place on June 12, 2018. During this meeting, many countries including Russia, Japan, South Korea were disappointed for being left out. It is because the nuclear bomb issue of North Korea has to involve more than 6 countries.

The meeting between Kim Jong-un and Donald Trump was unbelievable for Russia. It was not because Russia was outside from the geopolitical games, the reason was that they do not know well about North Korea's history, the leader's viewpoint, and managing technique. Russian publishers were still writing the dark side of North Korea only. The research of North Korea is very developed in Russia and I was part of this in 1992-1993, so believe me, my perspectives have accuracy.

The entire world except Russia was joyful, assuming Kim Jong-un actually banned the nuclear weapon program. Russian websites were warning Kim not to repeat Muammar Al Gaddafi's pitiful destiny in 2018. Also, there was a question of "What is the cost of this surrender?". Russia wondered why North Korea compromised even though it cost a lot of power, money, and capital in order to make rocket-fired nuclear weapons.

• We can invite anyone, but we need to be diligent and patient.

• The meeting between Kim Jong-un and Donald Trump was unbelievable for Russia.

• Russian authorities and researchers predicted that China will not be happy with the integration.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр.

Тендер шалгаруулалтын нэр: XII.1.1.178 "Дотуур байрын барилга" / Баян-Өлгий, Цэнгэл/ төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер.

Тендер шалгаруулалтын дугаар: ТӨБЗГ-2019/XII.1.1.178

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь эрх бүхий тендер оролцогчдоос: "Дотуур байрын барилга" / Баян-Өлгий, Цэнгэл сум/ ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ашиглан явагдаж буй цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан "Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Тендер оролцогч нь тендер илгээхийн өмнө 50,000.00 (Зохион мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:
- Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.
  - Байгууллагын дансны үлдэгдэл харилцагч банкны тодорхойлолтоор
  - Арилжааны банкны зээлийн тодорхойлолтыг тус тус тооцно.
- Сүүлийн 3 жил буюу зөвхөн 2016, 2017, 2018 оны аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй барилга угсралтын ажлын гэрээ байгуулж ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан байна. Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.

### Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай

- **БА-8.1.** Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил
- **БА-2.1** Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
- **БА-6.1.** Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- **БА-6.2.** Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- **БА-6.3.** Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,
- **БА-6.4.** Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт.

/Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна./

- Тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны "Аргачлал батлах тухай" 33 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу дүйцүүлж үзнэ.

**Тендерийн баталгааны дүн:** 16,181,000.00 (Арван зургаан сая нэг зуун наян нэгэн мянга) төгрөг. Монгол Улсын хуулийн этгээд тендерийн баталгааг банкны баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр ирүүлж болно.

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендер оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.

Тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 14.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 14.30 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулдаг цахим худалдан авах ажиллагааны төлбөргүй сургалтад хамрагдахыг зөвлөж байна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр, Нэг цэгийн үйлчилгээ, Утас: 62263014, 62263038**  
**Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

### MINING

## Over 400 coal trucks need to pass border to fulfill export target

The Government of Mongolia is planning to export 42 million tons of coal this year. In this regard, coal exports at Gashuunsukhait border checkpoint will be increased to 23 million tons from 18 million tons of last year. According to Erdenes Mongol LLC, about 400 coal trucks need to enter the border per day in order to fulfill this plan.

A spokesperson of the Infrastructure and Logistics Department of Erdenes Mongol LLC remarked, "The traffic congestion at the boarding pass depends on China's accessibility. Building parks will allow drivers to release the road

without waiting in line and relax. The parking lot is being constructed by a local private entity. Last year, about 1,600 cars were in operation at peak hours. Therefore, there are no problems with the capacity."

Security issues in Gashuunsukhait route road that involve 13 thousand vehicles in traffic are currently under discussion. The national auto transportation center controls the transport safety of Tavantolgoi - Gashuun Sukhait road. The organization is under the control of Gashuunsukhait Autoroad company.

There are 172 shipping service

providers who are responsible for enforcing labor safety regulations. These companies receive "C" licenses for international shipping from the National Transportation Department. Special security requirements must be met to obtain consent. However, according to sources, there are a number of companies that do not pay for the social security of transport drivers. In this connection, the Social Insurance General Office is planning to investigate companies that are making transportation via Gashuunsukhait. Appropriate actions will be taken if delict occurs. [ZGM]

# Өдрийн хэмнэл

## ТВ ХӨТӨЛБӨР



- 06.00** "7 хоногийн тойм" хөтөлбөр
- 09.00** "Цэрэг эрсийн жирийн өдрүүд" МУСК
- 11.00** "Монголын мэдээ" мэдээллийн хөтөлбөр
- 15.45** "Шинжлэх ухааны цаг" хөтөлбөр
- 19.20** Дэлхийд Монгол цэргийн үнэ цэнэ
- 21.10** "Монгол омогшил" хүндэтгэлийн концерт
- Bloomberg TV Mongolia**
- 07.00** "Ногоон хот" нэвтрүүлэг
- 11.00** "#Made in Mongolia" баримтат цуврал нэвтрүүлэг
- 14.00** "Суутнуудын намтар" нэвтрүүлэг
- 18.00** "Бизнесийн төв цэг" мэдээний хөтөлбөр - давталт
- 20.00** "Инновац-2050" нэвтрүүлэг
- 22.30** "Амжилтад хязгаар үгүй" нэвтрүүлэг
- БОЛОВСРОЛ HD**
- 11.45** Би Монгол хүн
- 13.50** Хөгжмийн цаг
- 14.10** "Эмоци продакшн" хошин шоу тоглолт
- 16.10** Монголчууд ХХ зууны эхэнд нэвтрүүлэг
- 20.40** "МонГал товчоо" VII. Амьдрал Урлахуй Жамьяндоржийн Отгонболд
- 23.05** "Нууц материалууд" ОАК 3.16-17-р анги
- МОНГОЛТВ**
- 10.30** "Хуурай эгч дүүс" СОАК 33-р анги
- 12.30** "Эх орон дуудаж байна" МУСК
- 16.00** "The Voice of Mongolia" шоу нэвтрүүлэг 16-р хэсэг
- 18.30** "Чимээгүй номын сан" / season1/ 4-р хэсэг
- 20.00** "Бүтэлгүй Севкат" ТОАК 10-р анги
- 22.00** "Сайн аав" МУСК

## ЗУРХАЙ



**Билгийн тооллын 12**  
Хаврын дунд улаагчин туулай сарын таван шар мэнгэгтэй, хөх бар өдөр  
**Үс засуулбал:** Өвчин эмгэг ирнэ.  
**Наран ургах, шингэх:** 06.59-19.00  
**Барилдлага:** Рашаан  
**Шүтэн барилдлага:** Хуран үйлдэхүй  
**Суудал:** Төмөр

## Аргын тооллын гуравдугаар сарын 18, Сумъяа гараг.

**Билгийн тооллын 12, үнэг одтой, хөх бар өдөр.**  
Өдрийн наран 06.59 цагт мандан, 19.00 цагт жаргана. Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, сүм дуганыг сэргээх, амьлуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Гөлөг тэжээх, золиг гаргах, бумбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, хүэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогосод баруун урагш мөрөө гаргавал зохистой.



**Эрчүүддээ**  
Хаана: Amrita Night Club  
Хэзээ: 2019.03.18-нд  
Тасалбарын үнэ: ₮20 мянга



**Япон поп соёлын өдөрлөг-2019**  
Хаана: Corporate Convention Centre  
Хэзээ: 2019.03.24-нд  
Тасалбарын үнэ: ₮10 мянга



**У.Шекспир "Ромео, Жульетта"**  
Хаана: УДЭТ  
Хэзээ: 2019.03.27-29-нд  
Тасалбарын үнэ: ₮10-30 мянга

## ОНЦЛОХ ҮЗВЭР



## ОЛОН УЛСЫН ЦИРКИЙН ТОГЛОЛТ

Олон улсын гайхамшигтай циркийн тоглолтыг энэ сарын 23-ны өдрөөс эхлэн АСА циркт толилуулах гэж байна. Олон улсын циркийн шилдэг уран бүтээлчид шилдэг үзүүлбэрүүдээрээ үзэгчдийг алмайруулах юм. 120 минутын турш таны нүдийг баясгах энэхүү гайхалтай цирк нь сургуультай нохой, морьтны тоглолт, агаарын амь эрсэн үзүүлбэр, хөгжөөн баясгах алиалагч, хүч тамирын гайхамшиг зэрэг шилдгийн шилдэг үзүүлбэрүүдээр үзэгч хүүхдүүд болон эцэг эхчүүдийн сэтгэлийг баясган догдруулах болно. [ЗГМ]



**Э.Чойдог "Чойжид дагина"**  
Хаана: УДБЭТ  
Хэзээ: 2019.03.24-ний өдөр  
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга



**Сонгодог хөгжмийн концерт**  
Хаана: Улсын филармони  
Хэзээ: 2019.03.20-нд  
Тасалбарын үнэ: ₮25 мянга




**"Хайрын урь" тоглолт**  
Хаана: Corporate Convention Centre  
Хэзээ: 2019.03.30-нд  
Тасалбарын үнэ: ₮20-30 мянга

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

III.18	III.19	III.20	III.21	III.22
11° / -4° 7 м/с / 8 м/с	-2° / -10° 7 м/с / 5 м/с	3° / -14° 7 м/с / 6 м/с	0° / -13° 7 м/с / 6 м/с	3° / -11° 7 м/с / 7 м/с
Үүлшинэ	Үүл багасна	Багавтар үүлтэй	Бага ээргийн тунадастай	Үүл багасна



## ФОТО АГШИН



1949 оны 11 дүгээр сарын 7-нд нийслэл Улаанбаатар хотноо анхны илчит тэрэг дуут дохио хангинуулан орж ирснээр Монголын төмөр замчдын түүх эхэлсэн. Өдгөө Монгол Улс 16 мянган төмөр замчинтай болжээ.

## ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1	2	3	4	5	6	7	8	9
		10			11		12	
13			14					
		15		16				
17							18	
19			20					21

зэвсэглэлд элбэг байсан гар буу

### ХӨНДЛӨНГӨӨР:

1. Ялалтын маршал
4. Хашиж хаасан байдал
7. Ардын хувьсгалаас өмнө манай оронд цөмрөн орж ирсэн хятад цэргүүдийг нэрлэдэг нэр
10. Аматай цуг мэргэжлийн сумод хөл тавьсан Монгол бөх
11. Японы Ерөнхий сайд
12. Дорнодын их тал
6. Алтан ургийн хааны угсааны хүний цол хэргэм номын багш
7. Хэлмэгдэж алагдсан Ерөнхий сайд, УБХ-ын анхны дарга
8. ОХУ-ын байлдааны сөнөөгч онгоц
9. МУГЖ Д.Жаргалсайханы дуу ... Монгол орон
17. ... чадвар
18. Макаровын өмнө Оросын цэргийн

13. Дэлхийн II дайнд Герман, Япон улсуудтай нэгэн эвсэл болон оролцсон улс
14. Хар арьстнуудыг нэрлэдэг нэр
15. Цагдаагийн хэрэгсэл
16. Зэвсэг
19. Жужан улсын өөр нэр
20. Улсын хилээр нэвтрэгсдийг шалган байцаах алба
21. ... орон, газар

Д	А	М	Д	И	Н	Ш	А	Р	А	В
Э	А	Р	И	Т	А					
М	А	Н	Д	А	Х	Н	А	Р	А	Н
Б	Х		Н	Г						К
Э	А			Э	А	П	У			
Р	Э	Н	Ц	Э	Н	О	Р	О	В	
Э		О	А		А					Е
Л	О	О	Л	Ь		Б	Я	Л	А	Р

Өмнөх дугаарын харуу / 03.15

## ЗГМ: СУДОКУ

8				4	5				
5		6		4					
9		1							
		5	7	1					
		6						9	
		2				5	6		
				1					8
				4	8	7			1
3				2					

7	9	6	1	2	3	8	5	4
5	3	2	7	8	4	1	6	9
4	1	8	9	6	5	7	2	3
3	8	7	6	4	9	2	1	5
9	5	4	2	7	1	6	3	8
6	2	1	3	5	8	9	4	7
1	6	5	8	3	7	4	9	2
8	4	9	5	1	2	3	7	6
2	7	3	4	9	6	5	8	1

Өмнөх дугаарын харуу / 03.15



## ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-МОСКВА	13.50	14.28
ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-БЭЭЖИН	07.15	14.04
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48



## НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-ХӨХ ХОТ	10.30	12.00
ХӨХ ХОТ-УБ	13.00	14.40

**КОМПАНИЙН НЭР ӨӨРЧЛӨХ ТУХАЙ**  
6232426 тоот регистрийн дугаартай "Хүн Ян" ХХК нь нэрээ өөрчилж, "Монголиа Найрамдал Констракшн" ХХК нэртэй болсныг мэдэгдэе.



# ЭДИЙН ЗАСАГ



## Закербергийн муу өдрүүд улам дордлоо

АНУ-ын сенатч хийгээд Ерөнхийлөгчид нэр дэвшигч Элизабет Уоррен түүний компанийг хуваах санал дэвшүүлжээ. > 10

## Хүний үр хөврөлийн ДНХ өөрчилдгийг хориглохыг уриалав

Ёс суртахууны хэм хэмжээг хатуу баримтлагч нар генийн засварын технологийг хүнд хэрэглэхийг хориглохыг уриалцаав. > 10

# Холбооны Нөөцийн Системийн арга хэмжээ үр дүн муутай

### Елена Полина

Холбооны Нөөцийн Систем хөрөнгө оруулагчдын сэтгэлийг амрааж нэгдүгээр сард “тагтаа”-ны бодлогодоо эргэн шилжсэний нөлөө илэрч байгаа бололтой.

Хүү өсгөх эсэхийг лхагва гарагт шийдэхээс өмнө S&P 500 индекс дээшилж, хувьцааны сангуудад мөнгө сүүлийн нэг жилд тохиолдож байгаагүйгээр цутгалаа. S&P 500 индекс 2.9 хувь дээшилсэн нь 2016 оноос хойш бодлогын хүү өсгөхийн өмнөхөн үүсдэг өсөлт дотроо үнэмлэхүй нь болов.

Тус системийн тэргүүн Жером Пауэлл “харцага”-ын байр сууринд шилжиж буйгаа нэгдүгээр сард зарлаж АНУ-ын хувьцааг баавгайн зах зээлийн ирмэгт аваачсан нь хөрөнгө оруулагчид сэрээж өгсөн. Гэхдээ л хөрөнгө оруулагч нар саяхан болтол эдийн засгийн

гутранги статистик, худалдааны дайны баргар нөхцөлөөс шалтгаалан мөнгөө хэтгэвчиндээ хадгалж, эдийн засгийн сэргэлтэд зориулахаас цааргалж байлаа.

“Холбооны Нөөцийн Систем тоглоомыг бүхэлд нь өөрчилсөн тул зах зээл боломжийг ашиглаж байгаа хэрэг” хэмээн Front Barnett Associates-ын хөрөнгө оруулалт хариуцсан захирал Маршалл Фронт тайлбарлав. “Холбооны Нөөцийн Системийн шийдвэрт түгшихээ больсон хөрөнгө оруулагчид тарифын асуудлыг шийдэгдэж, эдийн засгийн өсөлт сайжирна гэж боддог болсон”-ыг захирал өгүүлсэн юм.

АНУ-д хувьцааны үнэ Холбооны Нөөцийн Систем 2016 онд хүү өсгөснөөс хойш тохиолдож байгаагүйгээр өслөө.

S&P 500 индексийн хувьд 1991 оноос хойш тохиолдож байгаагүй

сайн эхлэл нь Холбооны Нөөцийн Системийн оролцоо харьцангуй бага үед тохиосныг JPMorgan Chase-ын статистик харуулав. Уг статистикаас үзвэл хедж сангуудад АНУ-ын үнэт цаас байрших хэмжээ бага буюу ердөө 25 процентиль болж байна. Зах зээлээс хожоо гаргах гол арга гутранги байр суурь болоод байгааг тус банкны квант эксперт Марко Коланович тайлбарласан юм.

Худалдааны сөргөлдөөнийг нэг мөр шийдвэрлэх АНУ, БНХАУ-ын уулзалт лавтай дөрөвдүгээр сар хүртэл хойшлогдож буйтай уялдан хөрөнгө оруулагчид лхагва гарагт гарах Холбооны Нөөцийн Системийн байр суурийг харзнаж байна. Пауэлл тэргүүдэд Холбооны Нөөцийн Систем бодлогын хүүгээ хэвээр нь хадгалж, тагтааны байр сууриндаа үлдэнэ хэмээн шинжээчдийн ихэнх



нь таамаглаж байгаа.

Бодлого тодорхойлогч нар тайлан тэнцлийг хэвийн болгох ажиллагаагаа хойшлуулж байгаагаа ойлгуулах нь зах зээлд нэмэлт хөшүүрэг болж өгнө. Бодит үнэнийг хэлэх аваас “Холбооны Нөөцийн Системийн тагтааны бодлогод гайхаад байх зүйлгүй”-г Wells Fargo Securities-ын үүсгэл үнэ цаасны стратегич Правит

Чинтаванованич анхааруулав.

S&P 500 индекс таван өдөр өссөний дүнд дөрвөн хувиар сайжирсан. Dow Jones Industrial Average индекс долоо хоногт 1.6 хувиар өслөө. Nasdaq 100 индекс 4.2 хувиар сэргэсэн нь 11 дүгээр сараас хойш тохиолдоогүй өсөлт болсон юм.

Одоогийн өсөлт цаашдаа үргэлжилнэ хэмээн хөрөнгө

оруулагч нар бооцоо тавьж байна. Хөрөнгө оруулагчид гуравдугаар сарын 11-нээр дууссан долоо хоногт АНУ-ын хувьцааны санд нийт 25.4 тэрбум ам.доллар оруулсан нь сүүлийн нэг жилийн хугацаанд тохиолдож байгаа хамгийн аварга урсгал болсныг EPFR Global-ын статистик харуулж байна.

Холбооны Нөөцийн Систем зах зээлд таатай нөлөөлж байгааг Miller Tabak + Co-гийн үнэт цаасны стратегич Мэтт Мэйли өндөр үнэллээ. “Ихэнх түгшүүр сарнисан ч сэтгэл амрах цаг эхэлж буй хэрэг биш. Юутай ч Холбооны Нөөцийн Систем зах зээлийн өөдрөг хувиралд гол үүрэг гүйцэтгэлээ. Зарим хөрөнгө оруулагч нар Холбооны Нөөцийн Систем энэ долоо хоногт зах зээлд шинэ сэргэлт авчирна хэмээн найдаж байгаа.”

### Уилл Вэйд

АНУ-ын эрчим хүчний салбарт нүүрс салшгүй амин чухал үүрэг гүйцэтгэсээр байна хэмээн долоон жилийн тэртээ Cloud Peak Energy Inc байдаг бооцоо тавьсан юм.


Бооцоо эдүгээ нүүрс олборлогчийг дампуурлын ирмэгт аваачаад байна. Тус компани Вайоминг, Монтангийн олборлоход хялбар ил уурхайн нүүрсээр цахилгаан станцуудыг хангана гэсэн тооцоонд тулгуурлан ажиллаж иржээ. Cloud Peak-ийн бизнес түрхэн зуур цэцэглэж, өрсөлдөгч нар нь зээлээ төлж дийлэлгүй ар араасаа дампуурцаах үед АНУ-ын гурав дахь гол нүүрс олборлогч болж амжсан удаатай. Гэтэл нүүрсэн галлагаат цахилгаан станцууд хаагдаж эхэлмэгц Cloud Peak-ийн үйлчлүүлэгч цөөрөв.

Ирэх долоо хоногуудад багтаан АНУ-ын дампуурлын хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу өргөдөл гаргаж болзошгүйгээ Cloud Peak баасан гарагт зарласан нь ерөнхийлөгч Дональд Трамп аврахаар яаж ч чармайгаад нүүрсний үйлдвэрлэлд зайлшгүй уналт нэгэнт нүүрлэсний илрэл боллоо. АНУ-ын Ерөнхийлөгч байгаль орчныг хамгаалах зарим зохицуулалтыг халчихаад байгаа ч цагтаа цахилгаан эрчим хүчний салбарын хаан байсан нүүрс илүү цэвэр эх үүсвэр болох шатдаг хий, сэргээгдэх эрчим хүчинд шахагдсаар ирлээ.

“Зарлуулах зохих бэрхшээл огт биш” хэмээн Clarkson's Platou Securities-ын шинжээч Жереми Сьюссман үзэж байна. Өнөө цагийн нүүрсний үйлдвэрлэлд Cloud Peak компани уул уурхайн аварга Rio Tinto Group-ээс салбарлан үүссэн алс тэртээх 10 гаруй жилийн өмнөхөөс эрс ялгаатай. АНУ-д нүүрсний олборлолт, хэрэглээ аль аль нь 33 гаруй хувиар буурчиглаа. Тухайн үед АНУ-ын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн талаас илүүг хангаж байсан нүүрс энэ онд 25-аас доош



## АНУ-ын эрчим хүчний зах зээлд бооцоо тавиад алдсан



хувьтай болоод байгааг АНУ-ын Эрчим Хүчний Мэдээллийн Захиргаа (US Energy Information Administration) тооцоолжээ.

Cloud Peak нь үйлдвэрлэлээ цахилгаан станцын дулааны нүүрсэнд төвлөрүүлсэн хэвээр. Гэтэл өрсөлдөгч Peabody Energy Corp, Arch Coal Inc өр зээл тавин байж үйлдвэрлэлээ ган хайлуулахад ашигладаг металлургийн нүүрсэнд шилжүүлцгээж байна.

Анх Cloud Peak илүү ухаалаг шийдсэн юм шиг санагдаж байсан үе бий. Нүүрсний үнэ навс унаснаас Peabody, Arch хоёр 2016 онд дампуурлаа зарлаж байхад Cloud Peak 21.8 сая ам.долларын ашигтай ажилласан. Тэгвэл эдүгээ хувь заяа эргэлээ.

Дээрх хуулийн дагуу дампуурлаа зарлаж бүтцийн өөрчлөлт хийснээс хойш Peabody, Arch хоёрын тайлан тэнцэл тогтвортой ашигтай байгаа. Ашигтай ажиллаж байгаа нь 2016 оноос хойш үнэ нь хоёр дахин өссөн металлургийн нүүрсний ач юм. Харин Cloud Peak энэхүү боломжийг ашиглаж чадсангүй.

Тус компани бас нэг боломж алдсан нь экспорт. Эрчим Хүчний Мэдээллийн Захиргааны статистикийг үзвэл АНУ-д 2018 онд нүүрсний экспорт 2016 оны үеэс 91 хувиар өссөн. Уг өсөлт үндсэндээ Аппалач, Иллинойсын хотгорын нүүрс. Гэтэл Cloud Peak-ийн аварга ил ордууд далайгаас олон зуун бээр алсад, Вайоминг,

Монтана муж улсын Паудэр голын ногоон хөндийд, Байцат уулсаар зааглагдсан таагүй байрлалд оршдог.

Тус компани олборлож буй нүүрснийхээ 11 хувийг гуравдугаар улиралд Ванкуверын терминалаар экспортод гаргахаар хэлэлцэн тохирсон. Гэтэл терминал хүргэх тэвэрийн урт зам уурхайн ашгийг “идэж орхив”. Вашингтон, Орегон, Калифорни муж улс эх газрын дотоодоос баруун эргийн терминалуудад нүүрс гаргахад хаалт тавьсан нь Cloud Peak-ийг ямар ч сонголтгүй болгов.

Холбооны нутаг дэвсгэрт олборлолт явуулахад олон сая ам.долларын роялти төлдөг Обамагийн үеийн зохицуулалтыг Цагаан ордон бүр 2017 онд хүчингүй болгосон. Энэ нь Cloud Peak-д даан ч хожимдсон тус боллоо. Хоёр жилийн өмнө буюу 2017 онд 6.6 сая ам.долларын алдагдалтай ажилласан тус компани өнгөрсөн онд 718 сая ам.долларын алдагдал хүлээнээ баасан гарагт тайлбарласан юм. Борлуулалт 14 хувиар багассантай зэрэгцэн олборлох зардал тонн тутамд 13 хувиар өсжээ.



## Apple Watch зүрхний өвчин илрүүлж чадаж байгааг судалгаа батлав

### Роберт Лангрет

Apple Watch зарим хүний зүрхний хэмтэй холбоотой онош тогтоож амжаагүй, далд гажгийг илрүүлж чадаж байгааг Стэнфордын их сургуулийн Анагаах ухааны сургуулийн судлаачдын судалгааны дүн нотлов.

Ухаалаг бугуйн цаг зүрхний тосгуурын бүлэгнэлийг (atrial fibrillation) байнга хуурамч түгшүүр зарлалгүйгээр зөв тодорхойлж байгааг Apple Inc-ийн ивээл дор, 419,297 хүнд явуулсан аварга цар хүрээтэй судалгаа харуулсан юм.

Илрэх шинж муутай далд гажиг болох зүрхний тосгуурын бүлэгнэлээ АНУ-д жилдээ 750 мянган хүн эмнэлэгт хэвтэж, 130 мянга нь хорвоог орхидог байна.



## БНХАУ тусгай бүсдээ гадаадын технологийн чадалтнуудыг татаж байна

### Роберт Лангрет

Хонконг, Макао өмнөд Хятадын том хотуудтай холбоосон нарийн технологийн бүсэд мэргэжилтэй ажиллаж хүч татах зорилгоор гадаадын авьяас чадвартнуудад татварын хөнгөлөлт үзүүлэх гэж байгаагаа БНХАУ-ын эрх баригчид мэдэгдлээ.

“Их булангийн бүс”-д ажиллах гадаадын өндөр ур чадвартай иргэдийг орон нутгийн удирдлага хувь хүний орлогын татвараас чөлөөлөх юм. Албан ёсны мэдээллээс үзвэл гадаадын нарийн технологийн ур чадвартай иргэдийг 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн таван жилийн хугацаатай хувь хүний орлогын татвараас чөлөөлж байна.

## Эдийн засаг

### Мишель Кортез

Хятад эрдэмтэн ихэр охидын ДНХ-д санаатай засвар оруулснаа мэдэгдэж, дэлхий нийтийг цочроосноос дөрвөн сарын дараа генетикийн тэргүүлэх шинжээч, ёс суртахууны хэм хэмжээг баримтлагч нар генийн засварын технологийг хүнд хэрэглэхийг хориглохыг уриалгаав.

Амьд хүүхэд бүтээх зорилгоор эр бэлгийн эс, өндгөн эс, үр хөврөлийн ДНХ-д өөрчлөлт оруулахыг бүх доктор, эрдэмтэд хатуу хориглохыг генийн засварын арга анх хөгжүүлэгчид хүртэл оролцож буй судлаачдын бүлэг дэлхийн улс орнуудад уриалж байна. Энэ хориг нь генийн засварын илүү хатуу чанд хяналттай шинэ стандарт бий болох хүртэл үйлчлэх юм. Шинэ стандарт мөрддөг болох хүртэл ДНХ засварын CRISPR технологийг нөхөн үржих эсийн бус түвшинд судалгаа хийх, эмгэг өвчин анагааж эмчлэхэд л ашиглах аж.

“Шинжлэх ухааны түүхэн дэх шийдвэрлэх мөч ирлээ. Энэхүү шинэ технологи хүмүүний амьдралын эх үндсийг шинээр бичих боломж бүрдүүлж өгнө” хэмээн Эрүүл Мэндийн Үндэсний Хүрээлэнгийн шинжлэх ухааны бодлого эрхэлсэн захирал Керри Фишер, тэргүүлэгч Франсис Коллинз тэргүүтэй эрдэмтэд Nature сэтгүүлд нийтлүүлсэн уриалгадаа хавсаргасан захидалд тайлбарлажээ.

Тэд “Хүний генийн засварыг нөхөн үржихүйн зорилгоор ашиглах нь нийгэм, ёс суртахуун, философи, шашин шүтлэгийн маш ноцтой үр дагавартай. Агуу их үр дагавартай зүйлийг асар нарийн эргэцүүлэх ёстой” хэмээв.

CRISPR хэрэглүүр нь ДНХ-ийн үсэг бүрдүүлэгч генийн кодын биетүүдийг “тасалж авах, наах” боломж олгодог. Уг хэрэглүүрийг генийн гажгаас үүдэлтэй өвчин эмгэгийг эмчлэх шинэ арга хэмээн үздэг.

Гэхдээ хэрэглэхэд харьцангуй хялбар байдгаас шалтгаалан өвчтөнийг хорлох, төрөөгүй



ДНХ засах ажиллагаа ойрын таван жилдээ хүний үр хүүхдэд турших хэмжээнд аюулгүй найдвартай болох магадлал хомс.

хэмээн судлаачид бичжээ. CRISPR-ийг хүний ДНХ өөрчлөхөд ашиглах нь өвчтөнд хор хөнөөл хүргэх, нийгмийн итгэлийг алдагдуулах зэрэг хавьгүй ноцтой уршигтайг гэд анхааруулж байна.

Уриалгад гарын үсэг зурсан эрдэмтдийн дотор Массачусетсын Технологийн Их Сургууль, Харвардын Их Сургууль хамтарсан Брод хүрээлэнгийн захирал Эрик Ландер, CRISPR технологийг анх хөгжүүлэгчдийн нэг - Берлин дэх Халдварын Биологийн Макс Планкийн хүрээлэнгийн захирал Эммануэль Шарпентье нар багтаж байна. Мөн уг технологийг хүний эсэд анх туршсан хүн болох Брод хүрээлэнгийн биохимич Фэн Жан ч уриалгад гарын үсэг зуржээ.

HIV буюу хүний дархлаа хомсдлын вирус тэсвэртэй болгохын тулд генд нь засвар хийсэн ихэр охид 11 дүгээр сард хорвоод мэндэлсэн тухай мэдээлэл нийтэд тарсан нь энэхүү уриалга гарах эхийг тавьсан юм. АНУ-д боловсрол олсон БНХАУ-ын эрдэмтэн, Шэньжэньд амьдардаг Хо Жянжун CRISPR ашиглан хийсэн өөрчлөтийн улмаас ихэр охид дэлхийн анхны генийн засвартай нялхас болсон. БНХАУ нь хүний үр хөврөлд генийн засвар оруулахыг хориглодог зохицуулалттай. Хоригийг нэр хүндтэй эрдэмтэд дэмжиж буйтай зэрэгцэн дэлхийн олон орон ийм практикийг хууль бус хэмээн зарлаад байна.

“Иймэрхүү зүйл тохиолдож болзошгүй олон оронд хүний генийн засвар хэдийн хууль бус болсон. Хятадад анх бүрхэг байсан зохицуулалт эдүгээ тодорхой болчихлоо” хэмээн Калифорни дахь Стэнфордын Их Сургуулийн био ёс зүйч Хэнк Грили анхааруулав.

ДНХ засах ажиллагаа ойрын таван жилдээ хүний үр хүүхдэд турших хэмжээнд аюулгүй найдвартай болох магадлал хомс хэмээн Грили үзэж байв. “Ойрын үед иймэрхүү үйлдлийг хүүхдэд турших нь гэмт хэрэг” хэмээн эрдэмтэн тайлбарлав.

# Хүний үр хөврөлийн ДНХ өөрчилдгийг хориглохыг уриалав

байгаа хүүхдэд шаардлагагүй засвар оруулахад CRISPR-ийг ашиглаж болзошгүй эрдэмтдийн сэтгэл түгшиж байна. Уриалга гаргасан эрдэмтэд

ийм шаардлагагүй засвараас үүдэлтэй, эдүгээ хэн ч хэлж үл мэдэх үр дагаврыг та бидний ирээдүй үеийнхэн үүрнэ гэдгийг сануулсан юм. Хориг тавих нь

CRISPR ашигладаг судалгаа туршилтын ажлыг удаашруулах эрсдэлтэй ч ноцтой технологийг буруу зорилгоор ашиглахыг зогсоох ач холбогдолтойг

судлаачид тайлбарласан юм.

“Эрдэмтдийн уриалга нь хүмүүний төрлийг шинэчлэн инженерчлэх хамгийн балмад төлөвлөгөөнд хаалт болж өгнө”

## Закербергийн муу өдрүүд улам дордлоо

### Молли Шуэц

Facebook-ын ерөнхий захирал Марк Закербергийн хувьд маш муу долоо хоног өнгөрлөө. Энэ сарын 8-нд эхний муу мэдээ сонсогдож, АНУ-ын Сенатч хийгээд Ерөнхийлөгчид нэр дэвшигч Элизабет Уоррен түүний компанийг хуваах санал дэвшүүлжээ. Дараа нь нийгмийн сүлжээний түүхэнд хамгийн удаан тасалдал гарч, өгөгдлөө алдсан хэрэгт шалгагдаж буй Facebook-ын үйлчилгээ түр хаагдав. Мөн ажлаа дөнгөж сэргээгээл хоёр чухал захирал нь халагдах өргөдлөө өгчээ. Гэвч хамгийн том цохилт баасан гарагт ирсэн нь Шинэ Зеландад 50 хүнийг хөнөөсөн аллагыг Facebook-ээр шууд дамжуулсан явдал байв.

Лупх Equity фирмийн шинжээч Жаханара Ниссар “Муу мэдээг хүртэл тайван ажигладаг хедж

сангууд ч гайхаж эхэллээ. Түүнчлэн стратегийн зөрчлөөс улбаалан хоёр захирал явж байгаа нь сэтгэл түгшээв” гэжээ. Иймэрхүү муу мэдээний хуримтлал компанийнх нь үнэлгээнд нөлөөллөө. Баасан гарагт эдний хувьцааны үнэ 2.5 хувиар унаж, 165,98 ам.доллар дээр иржээ. Twitter-ийн жиргээнд суурилсан судалгаанаас үзэхэд нийгмийн сүлжээнд хандсан сөрөг үзэл найман сарын дээд хэмжээнд хүрэв.

Facebook-ын талаар сэтгэгдэл өрсөж, урууддаг ч долдугаар сараас хойших жиргээ голдуу сөрөг өнгө аятай байна. Тэр үед орлого болон хэрэглэгчийн тооны өсөлтийн тааруу тайлан гарч, хувьцаа нь их хэмжээгээр зарагдсан. Ноён Уорренны санал нийгмийн сүлжээний хувьд шинэ, түгшүүртэй байдал үүсгэжээ.

Закерберг 2004 онд Харвард дахь оюутны байрандаа байгуулсан компани нийгэмд сайнаас илүүтэй муу зүйл авчраад байна уу гэх асуулыг хэрэглэгч, хууль тогтоогч, хөрөнгө оруулагч гэх мэт улам олон хүн тавих боллоо.

Facebook хэрэглэгчдийн өгөгдлийг муу хамгаалсан, үзэн ядсан үг яриаг хааж чадахгүй байгаа, буруу мэдээлэл тараадаг, хамгийн сүүлд хүчирхийллийг шууд дамжуулаа гэх шүүмжлэл, гомдол улам нэмэгдэж байна. Шинжээчид зохицуулагчид болон улстөрчид оролцох цаг нь болжээ хэмээн анхааруулж буй. Хатагтай Уоррен нийгмийн сүлжээг задлах саналаа Facebook-т тавьсан боловч тэр дор нь хаачихсан байв. Энэ нь олон нийтийн хэлэлцүүлэг, санаа бодлоо илэрхийлэх индэр гэх зарчмыг алдагдуулав.

Facebook-ын мэдэгдэлд

Уорренны сурталчилгаа компанийн логог ашигласан нь манай бодлогыг зөрчсөн хэмээн тайлбарлаад “хэлэлцүүлгийг идэвхжүүлэх үүднээс сурталчилгааг сэргээв” гэжээ. Өнгөрсөн лхагва гарагт эднийд хоёр хямрал нүүрлэв. Нью-Йоркийн 11.15 цагт Facebook-ын аппликэйшнээс эхлээд Instagram, WhatsApp сайтууд дэлхий даяар тасалдсан байна. Пүрэв гарагийн үдээс хойш хүртэл тасалдал үргэлжилсэн нь 2012 оноос хойш тэмдэглэгдсэн хамгийн удаан зогсолт боллоо.

34 настай Марк Закерберг зар сурталчилгааны хүчирхэг хэрэгсэл болох 2.7 тэрбум хэрэглэгчтэй нийгмийн сүлжээний хэзээ контентьг хянахад хүнд рэлтэйг хүлээн зөвшөөрсөн.

Тус компанийн бизнес загвар нь хүмүүсийн сэтгэгдэлд суурилдаг авч тэр нь цаашлаад хуурамч мэдээ, хэт үзлийг гараах суваг болдог. Гэвч Майамын их сургуулийн хуулийн профессор Мари Энн Франке “Амьд дамжуулалтын үйлчилгээг бодитойгоор зохицуулах боломж хомс” хэмээн дүгнэсэн байна.



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** XII.1.1.178 “Дотуур байрын барилга” / Баян-Өлгий, Цэнгэл/ төсөл арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер.

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** ТӨБЗГ-2019/XII.1.1.178

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь** эрх бүхий тендерт оролцогчдоос: “Дотуур байрын барилга” / Баян-Өлгий, Цэнгэл сум/ ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ашиглан явагдаж буй цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендер оролцогч нь тендер илгээхийн өмнө **50,000.00 (Тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түнхийг нээсэн өдрөөс хойш **45 хоногийн** хугацаанд хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**

- Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур

үүзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.

- Байгуулагын дансны үлдэгдэл харилцагч банкны тодорхойлолтоор
- Арилжааны банкны зээлийн тодорхойлолтыг тус тус тооцно.
- Сүүлийн 3 жил буюу зөвхөн 2016, 2017, 2018 оны аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй барилга угсралтын ажлын гэрээ байгуулж ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан байна. Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.

**Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай**

- БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил
- БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээгдсэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
- БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- БА-6.2. Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- БА-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,
- БА-6.4. Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт.

/Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна./

- Тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны “Аргачлал батлах тухай” 33 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу дүйцүүлж үзнэ.

**Тендерийн баталгааны дүн:** 16,181,000.00 (Арван зургаан сая нэг зуун наян нэгэн мянга) төгрөг. Монгол Улсын хуулийн этгээд тендерийн баталгаа банкны баталгаа, Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр ирүүлж болно.

Тендерийн материалд цахим тендерийн баталгаа хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргаж арилжааны банкны мэдээллийн сангаас тендер оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.

Тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 14.00 цагаас** өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 14.30 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулдаг цахим худалдан авах ажиллагааны төлбөргүй сургалтад хамрагдахыг зөвлөж байна. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр, Нэг цэгийн үйлчилгээ, Утас: 62263014, 62263038 Цахим хаяг: www.tender.gov.mn**

# Эдийн засаг

## БЛУМБЕРГИЙН ЗОЧИН

# Улс төр, эдийн засгийн бүлэглэл хоорондын дайн хамгийн том эрсдэл

**ДНБ-ий өсөлтийг эдийн засгийн өсөлт гэж тайлбарлаж болохгүй**

Бид эдийн засаг өсөж байна гэж яриад байдаг. Гэтэл энэ өсөлт энгийн иргэдийн амьдралд наалдсангүй. Ингээд бодит хөрсөн дээрээ бууж ирсэн нь хэрэглээгээ танах, зээл авахаа багасгах байдлаар илэрч байна.



С.Батсайхан / ЗГМӨ

### 3.Энхболор

Монгол Улсын 2019 оны эдийн засгийн ерөнхий төлөв болон гол эрсдэлийн талаар МУИС-ийн эдийн засгийн тэнхимийн багш Б.Эрдэнэбаттай ярилцлаа. Тэрбээр эдийн засгийн өсөлтийн суурь нөхцөл нь институцын чадавх, тогтвортой байдал хэмээгээд энэ оны нийт эдийн засгийн гол эрсдэл нь улс төр, эдийн засгийн бүлэглэлийн дайн болохыг анхаарууллаа.

**-Оны эхний хоёр сарын байдлаар инфляц 6.9 хувьтай байна. Инфляцын өсөлтийн хандлагаас ямар дүр зураг ажиглагдаж байна вэ?**

-Бидний зорилго бол инфляцыг найман хувьд барих. Харин одоогоор инфляц улсын хэмжээнд 6.9, нийслэлийн хэмжээнд 7.9 хувьтай байна. Ерөнхийдөө зорилготой түвшиндээ гэсэн үг. Эх үүсвэрийг нь задалж харвал нийлүүлэлт тал дээр ам.долларын ханшийн өөрчлөлт нэлээд нөлөөлсөн.

Харин манай улстөрчдийн ярих дургүй байдаг эдийн засгийн хамгийн чухал үзүүлэлт болох үндэсний нийт орлого сүүлийн гурван жил өссөнгүй. Тэгэхээр эрэлт талаасаа инфляцын дарамт байхгүй гэсэн үг.

**-Инфляцын цаашдын төлөвийг хэрхэн дүгнэж байна. Төв банкны зорилготой түвшинд бүтэн жилийн турш байж чадах болов уу?**

-Зорилготой түвшинд байна

байх. Гэхдээ инфляц бол тийм том асуудал биш. Угаас сүүлийн гурав, дөрвөн жилд инфляц нэг их том асуудал байгаагүй. Харин дефляц болчихлоо, яах вэ гэдэг асуудал байсан. Хэрэв “Эрдэнэт” үйлдвэртэй холбоотойгоор их хэмжээний ам.доллар Монголоос гараагүй бол инфляц бүр бага, цаашлаад дефляц болох нь гэдэг асуудалтай тулгарах байлаа.

**-Үндэсний нийт орлого гэдэг үзүүлэлт ДНБ-ээс яагаад чухал юм бэ?**

-ДНБ гэдэг тухайн тайлант хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэр дээр бий болсон нэмүү өртгийг хэмждэг зүйл. Энэ нь Монгол эх үүсвэртэй өсөлт байж болно. Мөн гадаадынхны Монгол Улсад үйл ажиллагаа явуулаад олсон ашиг бас тооцогдоно. Харин манайхны авч үлдэж байгаа зүйл буюу үндэсний хэмжээнд авч үлдэж байгаа орлогыг үндэсний нийт орлого гэж нэрлэдэг. Ялангуяа, уул уурхайн салбарт гадаадын асар их хөрөнгө

оруулалт хийгдсэн энэ үед ДНБ-ий өсөлтийг эдийн засгийн өсөлт гэж тайлбарлаж болохгүй.

### Хөрөнгө оруулагчид авлигын зардлаа давхар тооцдог болсон

**-Оны эхний хоёр сарын байдлаар зээлийн өсөлт жилийн өмнөх үеэс саарчээ. Хэрэглээний зээлийг хязгаарлах бодлогыг та зөв гэж үздэг үү?**

-Хүмүүст зөв мэдээлэл өгөхгүй бол эдийн засгийн буруу шийдвэр гаргаж эхэлдэг. 2018 онд ДНБ-ий өсөлт 6.9 хувьтай гарлаа гэж байна. Энэ нь манай эдийн засаг 6.9 хувиар өсөж, тэр өсөлтөөс нь бид хувь хүртэх юм шиг сэтгэгдлийг олон нийтэд төрүүлээд байгаа юм. Тиймээс хүмүүс эдийн засаг

сэргэж байгаа юм байна, яваандаа олон сайжирна гэсэн хүлээлтэй болж, үүндээ тулгуурлан зээл авах гэх мэт шийдвэр гаргадаг. Бидний сүүлийн хэдэн жилийн хэрэглээний зээлийн өсөлтийг үндэсний нийт орлогын өсөлттэй харьцуулбал сэтгэл сэртхийм дүн гарна.

Бид эдийн засаг өсөж байна гэж ярьдаг. Гэтэл энэ өсөлт энгийн иргэдийн амьдралд наалдсангүй. Ингээд бодит хөрсөн дээр бууж ирсэн нь хэрэглээгээ танах, зээл авахаа багасгах байдлаар илэрч байгаа юм болов уу.

**-2019 оны эдийн засгийн ерөнхий төлөв байдлыг та ямаар төсөөлж байна вэ?**

-Хэрэв ДНБ-ээ яривал эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайн байх төлөвтэй. Харин үндэсний нийт орлогыг яривал нэг их өсөлт гарахгүй болов уу. Бид урьдчилсан дүгнэлт хийхдээ хамгийн сүүлийн тоо баримтад тулгуурлах ёстой. Гэтэл 2019 оны гуравдугаар сар

талдаа орчихоод байхад өнгөрсөн жилийн үндэсний нийт орлогын үзүүлэлт гараагүй л байна. Ийм нөхцөлд таамаг дэвшүүлнэ гэдэг хэцүү.

**-Гол эрсдэл юу байх бол?**

-Авлига, хээл хахуулийн хэмжээ дэлхийн хэмжээнд яригдахаар том асуудал болчихлоо. Энэ мэдээд гадаадын хөрөнгө оруулагчдад нөлөөлнө. Тэд ямар хэмжээний өгөөжтэй төслүүдэд хөрөнгө оруулах вэ гэдгээ тооцохдоо авлигын зардал гэдэг зүйлийг давхар тооцдог болсон. Энэ хэмжээ нь жил ирэх тусам өсөж байна. Мөн улс төр, эдийн засгийн бүлэглэл хоорондын дайн болж байна. Энэ дайн нийт эдийн засагт маш том сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Эдийн засгийн өсөлтийн суурь нөхцөл нь институцын чадавх, тогтвортой байдал. Гэтэл бүлэглэл хоорондын дайн ихэвчлэн институцын чадавхыг устгадаг. Тэгэхээр энэ дайн хамгийн том эрсдэл, хамгийн том асуудал болчихоод байна.

## ЗГМ ТОВЧХОН

**» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**  
Монголын хөрөнгийн биржийн баасан гарагийн арилжаагаар 35 хувьцаат компанийн 110,733,242 төгрөгийн үнийн дүн бүхий 405,350 ширхэг хувьцаа арилжигдсанаас 13 компанийн хувьцааны ханш өсч, 17 компанийн хувьцааны ханш буурчээ.

Энэ өдөр “Нэхээсгүй Эдлэл” (NXE+14.71%) болон “Увс Чацаргана” (CHR+10.67%) ХК-ийн хувьцааны ханш хамгийн өндөр өсөлттэй байсан бол “Хай Би Ойл” (НВО-5.17%) болон “Гермес Центр” (HRM-3.57%) ХК-ийн хувьцаа хамгийн их уналттай байв.

### » НОГДОЛ АШИГ

**355**  
Төгрөг. “Баянгол Зочид буудал” ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 355 төгрөг буюу нийт 150.1 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

### » ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

**3022**  
Лиценз. Улсын хэмжээнд энэ оны гуравдугаар сарын байдлаар ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын 3022 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна.

## ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,631.60
Евро	2,981.21
Японы иен	23.56
ОХУ-ын рубль	40.24
БНХАУ-ын юань	391.83
БНСУ-ын вон	2.32

## УУЛ УУРХАЙ

# Гашуунсухайт боомтод нэг цэгийн үйлчилгээний зогсоол барина

**Б.Дашням**  
Шинжээч

Засгийн газрын тооцоогоор энэ онд манай улс 42 сая тонн нүүрс экспортолно. Үүнтэй холбоотойгоор өнгөрсөн онд 18 сая орчим тонн нүүрс нэвтрүүлсэн Гашуунсухайт боомтоор гарах нүүрсний хэмжээг 23 сая тонн болгож нэмэгдүүлэхээр болсон

юм. Төлөвлөгөөг биелүүлэхийн тулд боомтоор өдөрт дунджаар 400 тээврийн машин нэмж нэвтрүүлэх шаардлагатайг “Эрдэнэс Монгол” компаниас мэдээллээ.

БНХАУ-ын нэвтрүүлэх чадвараас хамааран боомт дээр түгжрэл үүсдэг. Харин нэг цэгийн зогсоол баригдсанаар жолооч нар цуваанд хүлээлгүй замаа чөлөөлж, амрах нөхцөл бүрдэх

юм байна. Зогсоолын бүтээн байгуулалтыг дотоодын хувийн хэвшил хариуцаж байгаа аж. Боомтын хүчин чадлын тухайд энэ жил нийт 23 сая тонн нүүрс нэвтрүүлэхийн тулд өдөрт дунджаар 1300 машин нэвтрүүлэх шаардлагатай. Өнгөрсөн жилийн оргил ачааллын үеэр өдөрт 1600 машин нэвтрэгч байв. Тиймээс боомтод ачааллын чанартай хүндрэл үүсэхгүй гэж мэдэгдлээ.

# Төмрийн хүдэр олборлогч компаниудын экспорт буурах бололтой

**М.Золбоо**  
Шинжээч

Төмрийн хүдрийн олборлолтоор тэргүүлэгч компаниудын экспортын дүн нэгдүгээр улиралд өмнөх жилийн мөн үеэс 2.5 хувиар буурч, 288 сая тонн болох төлөвтэй гэх урьдчилсан тооцооллыг Bernstein хийсэн байна. Энэ нь өмнөх тооцооллоос 200 мянган

тонноор буурсан дүн юм. Bernstein энэхүү таамагтаа Vale-аас гадна Rio Tinto, BHP, Fortescue Metals зэрэг томоохон компаниудыг хамруулжээ. Vale-ийн хувьд ослын улмаас энэ онд төмрийн хүдрийн гарц нь 50 сая тонноор буурна гэж тооцоолж байгаа аж. Харин бусад компани энэ дүнг нөхөх хэмжээнд гарцаа өсгөх боломжгүйг мэдэгдээд байгаа юм. Тэвэрийн мэдээллээс харахад

дээрх компаниуд сүүлийн нэг долоо хоногт 22.2 сая тонн төмрийн хүдэр экспортолсон байна. Энэ нь өмнөх долоо хоногийнхоос 2.7 сая тонноор буурсан дүн болжээ. Vale компанийн Бразил дахь уурхайн ослын дараах үр дагавраас шалтгаалаад энэ оны хоёрдугаар улиралд зах зээлд 12 сая тонн төмрийн хүдрийн хомсдол үүсэх төлөвтэй байгааг Credit Suisse анхаарууллаа.

“ЦЭЦ КАИНТАЛ” БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛГАЙН УДИРДАГААД

**АКΠΑΡ АУДИТ ХХК**  
2019.02.14

Хараат бус аудиторын тайлан

Дүгнэлт

Бид Аудиант тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу “Цэц каинтал” ББСБ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дугаар болон жилийн эцсийн санхүүгийн тайлан буюу Санхүүгийн байдалын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өөрийн өмчлөлийн тайлан, Мөнгө түрээслэх үйл ажиллагааны болон мөнгөн болон бүртгэлийн зардалтай байх суурь зарцыг ажиглаж авч үзсэн байна.

Бидний үзжээг харвал “Цэц каинтал” ББСБ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр төсөв болон бүтээгдэхүүн байгуулалтын талаарх тайлан болон бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу материаллаг арга, зөрчилгүй ажиглагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид зөвхөн аудитын ажлыг Аудиант Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-ын заасны аудиторын хүлээл үүрэг, зарчмуудыг “Санхүүгийн тайлангийн аудитын аудиторын хүлээл үүрэг, зарчмуудыг” гэсэн нэрээр тусгаж харуулав. Бид аудитын ажлыг хамаралтай хараат бус байдлаар болон ёс зүйн шаардлуудыг бүрэн биелүүлж ажигласан. Бидний өдөр ажил баримт ажиглагдсан дээрх зарчмуудыг гаргаж авч үзсэн үүрэг гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайлангаар уяарлагын хүлээл үүрэг, зарчмуудыг

Санхүүгийн тайлангаар СТОУС, Нэгтгэн болох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бүтэц, үзэм зөв тооцоож, нэгтгэн болох бүртгэлийн болзолын баримт бичгийг зохиогдож, стандарт, хууль нийцүүлэн боловсруулах, тогтвортой мөнгө ажлаах нь байгууллагын уяарлагын үүрэг болно.

Мөн түүнчлэн зарчмыг задалвал, хангалтгүй аюулгүй байдлыг хангах, зарчмыг жинг бүрэнгээ хангахад оруулахгүй байхад дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон мөнгөн болон бүртгэлийн зардалтай байх суурь зарцыг хангаж ажлаах нь байгууллагын уяарлагын зарчмууд юм.

Аудиант 3-р байр, Баянгол дүүрэг, 6-р хороо, Төв тэн 4 дүгээр, 807, 488 тооно, Утас/Факс: 976-11-821131, 976-91919758  
Ажлын 3-р байр, Баянгол дүүрэг, 6-р хороо, Хөдөөний тэнгэр, 7 дугаар, 798 тооно, Утас: 976-96012199, 976-96121999  
Э-мэйл: akpar.audit@cgf.com

АКΠΑΡ АУДИТ ХХК

Санхүүгийн тайлангийн аудитын аудиторын хүлээл үүрэг, зарчмуудыг

Аудиант гол зорилго нь үйлдвэрлэлийн санхүүгийн тайлангаар нь алдаа хэвлэлийн үйл ажиллагааны уламжлалыг бууруулахад анхаарч анхны зорилго дүгнэлт өгөхөд оршино. Тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулах зарчмын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотлох баримт болгох нь аудиторын үүрэг юм.

Аудиант гарчигуудыг баталсан талаархын дагуу аудитор өөрийн шийдвэр сонгох ба яриуулах алдаа, зөрчил нь материаллаг буюу байгууллагын зардална болон хэрэгжлэхийн дагуу зарчмыг шийдвэрлэхэд анхны зорилго дүгнэлт хийж, түүнд тохирсон дүгнэлт өгнө.

Аудиант шалгалтаар байгаа алдаа зөрчил илрэх ёстой гэсэн ойлголт байх болохгүй бөгөөд бидний зорилго алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг ажиглуулах талаар тодорхой мэдээлэл өгч ажлаах юм.

Цэц каинтал банкны хяналт бүтээгдэхүүн аудитын ажлын баримтууд нь тус компанийн өмч бөгөөд аудиторын тайлан, мөнгөний хангалттай байгаа бөгөөд түүнд хяналттай.

АКΠΑΡ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ  
Х.БАЯНБАЙ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“ЦЭЦ КАИНТАЛ” ББСБ

2018 оны 12 дугаар сар 31-ний өдөр

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Мөнгөний хөрөнгө	879,801,153.69	818,977,301.14
2	Зээл	52,310,000.00	9,900,000.00
3	Өндөр амттай	82,479,700.00	77,999,700.00
4	Урлагийн хөрөнгө	874,617.30	997,167.30
5	Бусад бусад хөрөнгө	300,000.00	300,000.00
6	Нийт хөрөнгөний дүн	974,964,471.19	907,474,168.64
7	Эрх зүйн хөрөнгө	15,946,501.45	5,481,124.45
8	“Эцэст” үнэт зүйлс	1,000,000,000.00	1,000,000,000.00
9	Урьдчилсан ашиг	(79,781,830.26)	(98,508,915.79)
10	Нийт орлого (зөвхөн өөрийн хөрөнгө)	974,964,471.19	907,474,168.64
Орлогын дэлгэрэнгүй тайлан			
1	Дүрвэл орлого	-	2,140,900.00
2	Дүрвэл зардал	-	-
3	Цэц каинтал орлого	-	2,140,900.00
4	Дүрвэл зардал	-	-
5	Дүрвэл зардал	-	32,539,728.00
6	Цэц каинтал бус орлого/зардал дүн	-	(32,539,728.00)
7	Энгийн үйл ажиллагааны орлого/зардал дүн	-	(32,539,728.00)
8	Энгийн үйл ажиллагааны зардал	-	27,210,000.00
9	Энгийн үйл ажиллагааны зардал	-	(87,788,828.00)
10	Урлагийн үйл ажиллагааны орлого	354,000.00	354,000.00
11	Урлагийн үйл ажиллагааны зардал	-	1,216,207.53
12	Энгийн үйл ажиллагааны зардал	354,000.00	(88,925,125.53)
13	Урлагийн үйл ажиллагааны зардал	-	-
14	Энгийн үйл ажиллагааны зардал	-	-
15	Энгийн үйл ажиллагааны зардал	354,000.00	(88,925,125.53)
16	Энгийн үйл ажиллагааны зардал	433,472.53	-
17	Цэц каинтал	(377,411.86)	(88,925,125.53)
Өөрийн өмчлөлийн тайлан			
1	1 дүгээр сарын 01-ний үзэгдэл	1,099,099,099.00	948,618,168.74
2	Өсөлт/бууралт	-	-
3	Бусад өөрчлөлт	(79,781,830.26)	(79,781,830.26)
4	12 дугаар сарын 31-ний үзэгдэл	948,618,168.74	948,618,168.74
Мөнгө түрээслэх тайлан			
1	Үйл ажиллагааны мөнгө түрээслэх дүн	688,577,679.14	(19,579,055.64)
2	Урлагийн үйл ажиллагааны мөнгө түрээслэх дүн	(963,302.95)	(1,243,797.53)
3	Бусад өөрчлөлт	487,794,236.05	(38,822,852.53)
4	Мөнгө түрээслэх мөнгө түрээслэх үзэгдэл	152,009,817.64	879,801,153.69
5	Мөнгө түрээслэх мөнгө түрээслэх үзэгдэл	879,801,153.69	818,977,301.14

# Эдийн засаг

**Монголын санхүүгийн зах зээл банкны систем дээр оршин тогтнож байна**

**Б.Баяртогтох**  
@bayartogtokhZGM

Арилжааны банк үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин манай улсад 1990 онд тавигдсан. Тухайн үеийн Сайд нарын зөвлөл 422 тоот тогтоол гаргасан нь улсад аж ахуйн банк буюу хувийн банк байгуулахыг зөвшөөрсөн явдал юм. Ингэснээр Монгол Улсад банкны хоёр шатлалт тогтолцоо бий болж, өнөөдрийн арилжааны банкны түүх эхэлсэн билээ. Эргэн харахад, өнгөрсөн 29 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн амьдралд өчнөөн зүйл өөрчлөгдөж, банк гэдэг ойлголт бидний хувьд хэрэгцээ, шаардлага болон хувирчээ.

Мөнгөний гэнэтийн хэрэг гарлаа гэхэд ойр тойрны нэгнээсээ сураглахаас илүүтэй банк бидний очих газрын нэг болтлоо энэ амьдралтай холбогджээ. Цалингийн зээл, байрны зээл, автомашины зээл энэ бүхэн байгаагүй бол хэзээ мөнгөө хурааж, хэзээ нь байртай, машинтай болох байснаа ер төсөөлшгүй. Энэ төрлийн үйлчилгээг төв банк бус түүний хараа хяналт дор үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкууд иргэдэд олгож, санхүүгийн хэрэгцээгээ банкны тусламжтайгаар хангаж өдий хүрлээ. Цаашдаа ч ийм байх нь дамжиггүй.

Дэлхий нийтээр банк, санхүүгийн үйлчилгээг авснаар боломжоо нэмэгдүүлж, цаг хугацааг хэмнэж, амьдралаа сайжруулж байна. Хувийн хэвшлийн томоохон компани, аж ахуйн нэгжээс эхлээд өрхийн үйлдвэрлэл хүртэл банкны зээлээр бойжиж, өөрсдийн өндөрлөгт хүрчээсэн юм. Иргэдийн хадгаламжийг гатан төвлөрүүлж, хэрэгцээтэй байгаа хэсэгт нь зээл болгон гаргаснаар банкны зуучлал хөгжиж, өнөөдөр бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ хоорондоо тэд өрсөлдөж, төрөлжиж байна. Үүнийг бичих сэтгүүлч миний хувьд ч ялгаагүй банкны зээлээр наад захын хэрэгцээгээ хангаж, байрны зээлд хүртэл хамрагдсан нэгэн. Хувь хүний санхүүгийн сахилга баттай ч болгосон. Хэрэв мөнгөө хураагаад байртай болно гэвэл залуучуудын хувьд бараг л боломжгүй. Залуу гэр бүлүүд урьдчилгаа нөхцөлөө хангаж л байвал орон байртай болох боломжийг банк олгож байгаа.

Арилжааны банк бий болсноор хүн хувийн өмч хөрөнгөтэй болж, баялгийн эзэн болсон. Тухайлбал, хувийн хэвшлийн дийлэнх нь банкны зээлээр босож ирсэн юм. Банкны салбар хамгийн ээдрээтэй, хүнд хэцүү цагийн шалгаралд орж, тэндээс тэсэж үлдсэн нь өнөөдрийн санхүүгийн зах зээлийн 95 хувийг бүрдүүлж байна. Алдаа оноо нь олон нийтэд ил,



Эдийн засаг өнгөрсөн онд 6.9 хувиар өсөхөд банкны салбарын үүрэг, оролцоо хамгийн их байсан.

## Банк бол улстөржүүлэх, оноо цуглуулах "хөзөр" биш

хүмүүсийн итгэл дээр оршин тогтнож ирсэн банкны салбар хамгийн өрсөлдөх чадвартай салбарт тооцогдож, үйлчилгээ, бүтээгдэхүүнээрээ эрс ялгарах боллоо.

Нөгөө талдаа банкны хөгжил эрчимжиж, түүний нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг, оролцоо нэмэгдэх хэрээр банк гэдэг санхүүгийн тогтвортой байдлыг илтгэх чухал багана болж байна. Эдийн засгийн тусгаар тогтнолын нэг хэмжүүр ч нь банк гэгдэх хэмжээнд ирлээ. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн хурдасгуур нь банк болж, хүмүүсийн ахуй амьдралд ч тэр банкаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны тулгамдсан асуудлыг шийдэж байна. Хэрэв банкны систем гэнэт байхгүй боллоо гэж бодоход хэн бидэнд банк шиг бага хүүтэй, урт хугацаатай зээлийн үйлчилгээ санал болгох вэ. Хэн бидэнд итгэж хэрэглэний зээл олгож, хөл дүүлжх унаатай болгох вэ. Ингээд бодохоор банк зөвхөн

ашгийн төлөө бус нийгмийн төлөө хариуцлага хүлээдэг байгууллага болж таарч байгаа юм. Тиймээс ч дэлхийн нийтээр банктай холбоотой мэдээлэлд хамгийн эмзэг, хамгийн хариуцлагатай ханддаг.

Популист улстөрчийн хийтэй үг, үйлдэл, тэдний гаргасан ойлворгон гэнэтийн шийдвэр бүхэл бүтэн банкны систем, үүнээс улбаалан эдийн засгийн урт хугацааны хямрал, уналтыг дагуулах хэмжээний эрсдэлтэйг хэн хүнгүй бодох учиртай. Банк харилцагчийнхаа өмнө, хадгаламж эзэмшигчийнхээ өмнө, нийгмийн өмнө ямагт хариуцлага хүлээж байдаг. Тиймээс банкны салбар, түүний дотор системийн нөлөө бүхий банк руу чиглэсэн халдлага, нийгмийг төвдүүлсэн огцом мэдэгдэл болгон нь эдийн засгийн эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлийн нэгд тооцогддог.

Тухайлбал, Худалдаа хөгжлийн банктай холбоотой, тус банк руу чиглэсэн дайралт

эргээд санхүүгийн салбарт хамгийн том цочроо болж, олон нийтэд харилцан адилгүй цуурхал түгсэн. Монголын банкны системийн 25 хувийг бүрдүүлдэг, олон талт банк гэж тодотгодог тус банк руу бүлэглэн дайрсан явдлууд нийгмийг, бизнесийн орчныг айдас хүйдэстэй болгосон гэхэд хилсдэхгүй.

Санхүүгийн зах зээлийн 95 хувийг банкны систем бүрдүүлж байгааг эхэнд дурдсан. Банк өөрөө нийгэм, эдийн засагт хамгийн том хариуцлага үүрч яваа нөхцөлд хий хардах эсвэл гүтгэх чухамдаа улсаа нураах ч аюултай. Банк бол улстөржүүлэх, оноо цуглуулах "хөзөр" биш юм. Улсад олон улсын санхүүгийн зах зээлээс валют авчирдаг, Монголын банкны салбарын нэр нүүр болсон, гадаад төлбөр тооцооны 80 гаруй хувийг хийдэг Худалдаа хөгжлийн банкны нэр төрд санаатайгаар бүдүүлгээр халдсан үйл явдал эргээд Монголд итгэх хөрөнгө

● **Хувийн хэвшлийн томоохон компани, аж ахуйн нэгжээс эхлүүлээд өрхийн үйлдвэрлэл хүртэл банкны зээлээр бойжиж, өөрсдийн өндөрлөгт хүрчээсэн.**

● **Банкны салбар хамгийн эдрээтэй, хүнд хэцүү цагийн шалгуурт орж, тэндээс тэсэж үлдсэн нь өнөөдрийн санхүүгийн зах зээлийн 95 хувийг бүрдүүлж байна.**

● **Мөнгөний гэнэтийн хэрэг гарлаа гэхэд ойр тойрны нэгнээсээ сураглахаас илүүтэй банк л бидний очих газрын нэг болтлоо энэ амьдралтай холбогджээ.**

оруулагчдыг нүүрээ бууруулахад хүргэж байна. Энэ нь эдийн засагт хамгийн том шок гэсэн үг.

Валютын нөөцийг зузаатгахад хүчин зүтгэдэг банк Монголд хэд билээ. Хэрэв төв банкны нөөц дундарч, ширгэсээр байвал энэ нь ам.долларын ханш өсөх, улмаар бидний хэрэглээ улам үнэтэй болох наад захын эрсдэлд хөтлөх билээ. Ам.доллар тэргүүтэй валютын ханш өссөнөөр шатахууны үнэ нэмэгдэх, олон улсад төлөх Монгол Улсын өр ханшийн зөргүүнээс болоод улам л нэмэгдэнэ гэсэн үг. Том зургаар нь харвал, зүгээр нэг банкны эсрэг хийсэн харлалан дайралт бүхэл бүтэн эдийн засгаа эрсдэл рүү түлхэж мэдэх нөлөөтэйг анзаарсан болов уу. Жишээ нь, банкны салбар зөвгүйдэхэд, бүхэлдээ даалуу шиг эрсдэлд ороход танай байгууллагын цалинд хүртэл өөрчлөлт орох, хүндрэл үүсэх нөлөөтэй.

Иргэн хүний амьдралд хүртэл банкны үйлчилгээ авах боломж, бололцоо улам хумигдах эрсдэлтэй. Нөгөө талдаа иргэдийн хувьд банктай холбоотой цуурхалд итгэж, түүнийг ам дамжуулан ярихгүй байхаас хүртэл энэ нь хамаарна. Банктай холбоотой сөрөг мэдээллүүд жишээ нь өрсөлдөгчийнх нь зохион байгуулалттай тараасан цуурхал байсан бол яах вэ. Системийн нөлөө бүхий банк гэдэг бүхэл бүтэн салбарыг авч явдаг, цаашилбал, улсын эдийн засгийн тусгаар байдал, тогтвортой хөгжлийн баталгаа болдог. Тиймээс л эдгээрийг хөндлөө. [ЗГМ]

### ХӨРШ

## БНХАУ эдийн засгаа дэмжих бодлогоо үргэлжлүүлнэ

**Б.Номин-Эрдэнэ**  
Шинжээч

БНХАУ одоо хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих бодлогоо үргэлжлүүлэхээр болж байна. Мөн мөнгөний бодлогыг хэт зөөлрүүлэх,

төсвийн зарцуулалтыг огцом нэмэгдүүлэхээс зайлсхийнэ гэж тус улсын Ерөнхий сайд мэдэгдлээ. Тэрбээр Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын чуулганыг хааж хэлсэн үгэндээ "Эдийн засагт тулгарсан эрсдэлүүдийн эсрэг арга хэмжээ авах"-аа онцолсон

байна. Ингэхдээ зах зээлийн тоглогчдыг дэмжих санаачилгыг орхигдуулахгүй гэдгээ цохон мэдэгдлээ. Үүнээс гадна БНХАУ энэ онд 298 тэрбум ам.доллараар хэмжигдэх татвар бууруулах шийдвэрээ танилцууллаа. Дөрөвдүгээр сарын 1-нээс хэрэгжих энэхүү зохицуулалтад

аж үйлдвэрийн салбарыг дэмжих зорилгоор НӨАТ-ыг гурван хувиар бууруулах санаачилга багтжээ. Түүнчлэн АНУ-тай үүсээд байгаа "Худалдааны дайн"-ыг эцэслэхэд дэмжлэг болох гадаадын шууд хөрөнгө оруулалтын шинэ хуулиа баталлаа.

### ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

